ХОВД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг
Email:khovd@agency.edu.mn Утас: 70435178.

2024.12.19 № 414

танай ____________ -ны № ____________ -т

БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

2024 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулан хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА В.САЙНБАЯР

9067906 1624080069

010002041

**БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ**

Байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалыг дагаж, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 11 дугаар сарын 23-ны өдөр igovernment.mn цахим сайтад оруулсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр цахим системд тайлан бичиж боловсруулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт: 2024 оны тайланг цахим системд шилжүүлсэнтэй холбоотойгоор зарим зорилт, арга хэмжээг цахим системийн аргачлалын дагуу бүртгэсэн. Тайланд нийт 12 зорилт болон 61 арга хэмжээ бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн биелэлтийг холбогдох баримт, нотолгоонд тулгуурлан 2000 тэмдэгтэд багтаан тайлагнасан.

| ЗОРИЛТ | Арга хэмжээ | | Дундаж | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биелэлт бичих | Биелэлт бичсэн | 100% | 90% | 70% | 50% | 100>...>90 | 90>...>70 |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | 17 | 17 | 17 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 25 | 25 | 25 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 19 | 19 | 19 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **НИЙТ** | **61** | **61** | **61** | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Энэхүү дүнгээр 100% биелэлттэй бүртгэгдсэн бөгөөд бүх зорилтууд амжилттай биелсэн байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь өмнөх онуудаас илүү амжилттай хэрэгжиж, зорилтот арга хэмжээнүүдийг гүйцэтгэсэн гэж дүгнэх боломжтой. Удирдлагын манлайлал, бүтээлч хандлага, ил тод байдал, идэвхтэй хамтын ажиллагаа нь төслийн хэрэгжилтэд ихээхэн нөлөөлсөн нь тайланд тусгагдсан.

Хэрэгжилтэд гарсан саад бэрхшээл:

- Залуу багш нарын чуулга уулзалт зохион байгуулах арга хэмжээ: Залуу багш нарын холбооны үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтээс шалтгаалан, чуулга уулзалт зохион байгуулагдаагүй. Мөн “Стандарттай Ховд” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт хийж, сургуулиуд болон цэцэрлэгт чиглэл өгсөн ч ахиц гараагүй байна.

- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015-г нэвтрүүлэх: Тус арга хэмжээний биелэлт 70% байгаа бөгөөд зарим сургуулиуд, цэцэрлэгүүдэд энэ тогтолцоог бүрэн нэвтрүүлж чадаагүй байна.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр шинээр барих, өргөтгөл хийх арга хэмжээ: Энэ хичээлийн жилд 3 барилга хүлээн авах байсан бөгөөд 1 барилга хүлээн авсан тул биелэлт нь 70% байгаа.

Үнэлгээний баг өмнөх тайлангийн явцад шинжилгээ хийж, дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сараар болон улирлаар төлөвлөж, биелэлтийг тогтмол хянах. Биелэлт хэрэгжилтийг тухай бүр нэгжийн дарга хянаж, тасалдаж байгаа ажлуудыг тодорхойлж хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх.
- Бүтэц орон тоо, хүний нөөцөөс үл хамааран төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй. Хүний нөөцийн алдааг бууруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага тулгарч байна.
- Сар, улирал бүрд үнэлгээний баг тогтмол хяналт хийж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шаардлагатай. Хяналт, шинжилгээ хийх тогтмол механизмтэй байж, биелэлтийг сайн бүртгэн тэмдэглэх хэрэгтэй.
- 2024 оны төлөвлөлтийг igovernment.mn цахим системд бүрэн шилжүүлэх хэрэгтэй. Сар, улирлын төлөвлөлт хийж, удирдлагын үүрэг чиглэл, салбар байгууллагын болон шууд харьяалагдах байгууллагуудын төлөвлөлтөд уялдуулан ажиллах шаардлагатай.

Энэхүү тайлан нь байгууллагын жилийн гүйцэтгэлийг амжилттай дүгнэж, биелэлтийг цахим системд шилжүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагааг сайжруулах боломжийг олгосон. 2024 оны амжилт нь өмнөх онуудаас илүү байгааг харуулж байна. Дараа дараагийн төлөвлөлт болон хэрэгжилтэд гарсан алдаа, саадыг засаж, ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулах шаардлага байгаа гэдгийг дүгнэж байна.

Төлөвлөгөөг үнэлсэн:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батсайхан /Бодлогын хэрэгжилтийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч/

Гишүүд: Д.Батнасан /Сургалт, арга зүйн хэлтсийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч/

Б.Сайнсанаа /Байгалийн ухааны боловсрол хариуцсан ахлах арга зүйч/

Б.Уугантуяа /Хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан ахлах арга зүйч/

Б.Бямбаргачаа /Сургалтын орчин, хүүхдийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах арга зүйч/

Ажлын хэсгийн нарийн бичиг: Т.Буянжаргал /Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах арга зүйч/

Төлөвлөгөөний үнэлгээг баталгаажуулсан:

| | | |
|---|---|---|
| Боловсролын газрын<br>Дарга<br>(албан тушаал) | ........................................<br>(гарын үсэг)<br>9067906 1624080069 | Төсвийн шууд захирагч<br>В.Сайнбаяр<br>......................<br>(огноо) |

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Ховд аймгийн Боловсролын газар

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1. | Хүн амд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлэн тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй аймаг болох | 190.0 сая- орон нутгийн хөгжлийн сан, Батлагдсан төсөв | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | 90 | Боловсролын үйлчилгээг хүн амд чанартай хүргэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр "Чанартай боловсрол", багшлах боловсон хүчний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулах дэмжих, сургалтын чанарыг сайжруулах, оюутан сурагчдыг шагнах, тэтгэлэг олгох замаар ирээдүйн чадварлаг мэргэжилтэнг бэлтгэх чиглэлээр "Чадварлаг багш, оюутан, сурагч", Сургалтын байгууллагын менежментийг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх чиглэлээр "Тогтвортой хөгжлийн боловсрол", үндэсний өв соёл, эх хэлний дархлааг бий болгох, бичиг соёлын болон Монгол хэл бичгийн сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр "Монгол хэл бичиг" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласнаас гадна сурагч багачуудыг бага наснаас нь эрүүл мэндийг дэмжих, зөв хүн болгон төлөвшүүлэх "Хүүхдийн хоол тэжээлийн шимт дэмжлэг" арга хэмжээг хэрэгжүүлэн цэцэрлэгийн болон сургуулийн бага ангийн сурагчдад 7 хоногт 2 удаа 200гр сүү өгөх арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1 | Чадварлаг багш, оюутан, сурагч дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлий сан | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээр | 70 | Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 90 | Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах дэд хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна: Үүнд: "Чанартай боловсрол" хөтөлбөр: Хүн амд чанартай боловсролын үйлчилгээг хүргэх, хүртээмжийг сайжруулах зорилгоор боловсруулсан. Багшлах боловсон хүчний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулах, дэмжлэг үзүүлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. "Чадварлаг багш, оюутан, сурагч" хөтөлбөр: Орон нутгийн их сургуулийн оюутнуудад Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгож, ирээдүйн чадварлаг мэргэжилтэн бэлтгэхээр хэрэгжүүлж байна. "Тогтвортой хөгжлийн боловсрол" хөтөлбөр:Сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх, үр дүнтэй арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна."Монгол хэл бичиг" хөтөлбөр: Үндэсний өв соёл, эх хэлний дархлааг хамгаалах, бичиг соёл, Монгол хэл бичгийн сургалтын чанарыг сайжруулах зорилготой. "Хүүхдийн хоол тэжээлийн шимт дэмжлэг" арга хэмжээ: Бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, зөв хүн болгон төлөвшүүлэх зорилгоор цэцэрлэг болон сургуулийн бага ангийн сурагчдад долоо хоногт 2 удаа сүү өгөх хөтөлбаөрийг амжилттай хэрэгжүүлж байна.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.1.2 | "Чанартай боловсрол" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв | Чанартай боловсрол дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | Эхний хагас жилд: 85 Жилийн эцэст: 90 | "Чадварлаг багш, оюутан, сурагч" дэд хөтөлбөрийн хэрэгжилт. Энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд 3 зорилтын дагуу нийт 16 арга хэмжээг төлөвлөж, эхний хагас жилд 9 арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Эрдэм шинжилгээний болон сурган хүмүүжүүлэх арга хэмжээ: МУИС-ын баруун бүсийн салбар сургуультай хамтран “Боловсрол, сэтгэл судлалын орчин үеийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгууллаа. БСҮХ-ээс уламжлал болгон зохион байгуулдаг сурган хүмүүжүүлэх уншлагыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол гэсэн хоёр салбар хуралдаанаар зохион байгуулсан нь боловсролын салбарын мэргэжилтнүүдийн туршлага солилцох, шинэлэг санаачилга гаргах боломжийг олгов. Мөн улсын хэмжээнд СӨБ-ийн чиглэлийн эрдэм шинжилгээний хуралд 2 багш оролцож, улсад 1 дүгээр байр эзэлсэн. Уралдаан тэмцээн, багш нарын урамшуулал: хичээлийн жилийн туршид амжилт гаргасан нийт багш ажилчдыг 8 чиглэлээр нийт 565 сая төгрөгийг аймгийн орон нутгийн сангаас шагнаж, урамшуулсан. Өнгөрсөн хичээлийн жилд сургалт, мэдээлэл түгээх арга хэмжээ: Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9 дэх заалтын хүрээнд Засаг даргын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Илгээлт-2100” тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан Ховд аймгийн оюутнуудын санаачилгаар “Дэлхийн Монгол иргэн” төгсөх ангийн сурагчдад зориулсан сургалт, уулзалт зохион байгууллаа. Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан дөрвөн оюутан нийт 185 төгсөх ангийн сурагчдад мэдээлэл хүргэж, сурагчдыг ирээдүйн зорилгоо тодорхойлох, чадварлаг мэргэжилтэн болох урам зориг өгөхөд хувь нэмэр оруулсан. Америкт төгсөгчдийн MASA байгууллагатай хамтран гадаадад суралцах талаар нийт 2500 сурагчдыг хамруулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнүүд нь боловсролын чанарыг сайжруулах, багш, оюутан, сурагчдын ур чадвар, идэвхийг нэмэгдүүлэх, ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Medlee цахим сургуулийн нийт 13 багшийг тус бүрийг 500.000 төгрөгөөр урамшуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 100 | |
| 1.1.3 | Тогтвортой хөгжлийн боловсрол дэд хөтөлбөр хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | Эхний хагас жилд: 80<br>Жилийн эцэст: 90 | Тогтвортой хөгжлийн боловсрол орон нутгийн дэд хөтөлбөр 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангаас 16.690.000 сая төгрөгийн дэмжлэгтэй 2 бүтээлч ажил явагдсан. Нийт үйл ажиллагааны дундаж биелэлт 96%тай үнэлэгдсэн өмнөх оны хэрэгжилт 16% иар ахиулсан байна. Суралцагчид өөрсдийн зохион байгуулж буй байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг сургуулийн нийт хамт олон, харьяа орон нутаг дэвсгэрийн оршин суугчдад сурталчлан таниулж үйл ажиллагаандаа уриалан оролцуулах нийтийн хандлагад нөлөөлөн тэдний дэмжлэг авах, шинэ санаачилга өрнүүлэх хандлагыг бий болгох зорилготойгоор 26 сургуулийн 52 сурагчдад “ сургуулийн эко клубийн сурагчдад "Байгальд ээлтэй -Ховдын хүүхэд " сэдэвт зөвлөлдөх уулзалт,хими биологийн багш нарыг чадваржуулах сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 09-10-ны хооронд зохион байгууллаа. Сургалтыг ГБХЗХГ, БОАЖГ, Хар нуур -Ховд голын сав газрын захиргааны мэргэжилтэн нар хамтран зохион байгуулав. Зөвлөгөөнөөс "Байгальд ээлтэй- Ховдын хүүхэд" загвар санаа, хэрэгжүүлэх зөвлөмж уриалгыг оролцогч сурагчид маань хамтран хэлэлцэж тодорхойлон энэ хичээлийн жилд хэрэгжүүлэн туршина. Мөн аймгийн эко клубийн сурагчид харилцан мэдээлэл солилцох нэгдсэн цахим бүлгийг нээсэн. Сургууль бүхлээрээ ажиллах арга, хандлагыг сургуулийн үйл ажиллагаанд түгээх” бүтээлч ажилд 25 сургуулийн 130 багш,удирдлага оролцсон<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Монгол хэл бичиг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 90 | Төрийн байгууллагууд гадна хосолсон жижиг хаяг, том гэрэлт хаягтай, дотно өрөө тасалгаа, мэдээллийн самбараа хос бичгээр бичиж хаягжуулан, монгол бичгийн орчин бүрдүүлж тохижуулсан. Аливаа шагнал урамшууллыг монгол бичгээр хослуулан бичиж хэвшсэн. Уран бичлэгийг сонирхогчдын тоо нэмэгдэн, бийрийн дугуйлан, сургалтад давхардсан тоогоор 500 орчим сурагч, иргэд хамрагдсан. Төрийн байгууллагын архив бичиг хэргийн ажилтнуудад үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, албан хэргээ хос бичгээр бичиж туршиж эхэлсэн “Хос бичигтэн Ховдчууд” цахим хуудсаар дамжуулан монгол бичигтэй холбоотой бичвэр байршуулснаас гадна мэдээ, мэдээлэл, зохион байгуулж буй үйл ажиллагааны явц, хэрэгжилтийг сурталчиллаа. Үндэсний бичиг үсгийн баярыг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Соёл урлагийн газар, Хэлний салбар зөвлөл хамтран жил бүр тодорхой уриан дор зохион байгуулж, аяны хүрээнд зохион байгуулж буй үйл ажилаагааны ангилал, оролцогчдын тоо, нэмэгдсэн. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх бүтээлч уралдааныг 5 ангиллаар зохион байгуулж урамшууллаа.<br>Хүрсэн түвшин: 95%<br>Хавсралт: 6 файл | 100% |
| 1.1.5 | Хүүхдийн хоолны шим тэжээлийн дэмжлэг "Сүү" төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ | 1.734сая - орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв | Хүүхдийн хоолны шим тэжээлийн дэмжлэг "Сүү" төсөл, арга хэмжээнд хамрагдсан | Ерөнхий боловсролын сургуулийн 10164, цэцэрлэгийн 6597 | Эхний хагас жилд: Ерөнхий боловсролын сургуулийн 10164, цэцэрлэгий | Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны хөтөлбөрийн шинэчлэлийг эрчимтэй хийж байна. Үүнд: Хөтөлбөрийн шинэ зохион байгуулалт: өмнө нь түрээсийн гэрээгээр зохион байгуулагдаж байсан ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн хоолны үйлчилгээг зогсоож, сургуулиудыг шууд удирдлага, зохион байгуулалтад авч ажиллуулсан. 1-12 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхэд багачуудын тоо | | н 6597 Жилийн эцэст: Ерөнхий боловсрол ын сургуулийн 10164, цэцэрлэгий н 6597 | ангийн сурагчдын 82 хувийг хүүхдийн хоол хөтөлбөрт хамруулж, хоол тэжээлийн хүртээмжийг мэдэгдэхүйц сайжруулсан. ARTA программын нэвтрүүлэлт:хүүхдийн хоолны зохион байгуулалтыг илүү үр ашигтай, хяналттай болгохын тулд ARTA программыг нэвтрүүлэн ажиллуулж байна. Энэ нь хоолны төлөвлөлт, хяналт, хоолны шим тэжээлтэй байдлыг оновчтой удирдах боломжийг бүрдүүлсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг: Тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж, хоол бэлтгэл болон ариун цэврийн стандарт шаардлагыг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн. Аяга, таваг угаах 3 шаттай дамжлагатай угаалтуур болон ариутгалын тоног төхөөрөмж суурилуулж, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйг сайжруулсан. Үр нөлөө: Сурагчдын эрүүл мэнд, хоол тэжээлийн чанарыг дээшлүүлэхээс гадна орон нутгийн боловсролын чанарт эерэг нөлөө үзүүлж байна. Хоолны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах нөхцөл бүрдсэн нь сурагчдын сэтгэл ханамж, эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлж байгаа юм. Энэхүү шинэчлэл нь сургуулиудын хоол үйлдвэрлэлийн чанар, хүртээмжийг сайжруулж, хүүхдийн эрүүл өсөлт хөгжилд чухал ач холбогдолтой алхам болж байна.<br><br>Хүрсэн түвшин: 100%<br><br>Хавсралт: 1 файл | |
| 1.2. | Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд төлөвлөх, зохион | Улсын болон батлагдса н төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлтүүд | Арга хэмжээ тус бүрийн суурь түвшин | Арга хэмжээ тус бүрийн зорилтот түвшин | Салбарын 24 сургууль, 33, цэцэрлэг, 1 политехник коллежи, 2 насан туршийн боловсролын төвд мэргэжил арга зүйн болон захиргааны удирлагын хүрээнд хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг ханган ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | | | | | | |
| 1.2.1 | Шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сурталчлах | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Хууль, эрх зүйн баримт бичгийг сурталчлан таниулах арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 462 | Эхний хагас жилд: 1000 Жилийн эцэст: 1500 | Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран 2024 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд Ховд аймагт “Боловсролын багц хууль” сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, Хөгжил политехник коллеж, МУИС-ийн баруун бүсийн сургууль, Насан туршийн суралцахуйн төв зэрэг 68 байгууллагын 85 албан хаагч оролцсон. Сургалтад хамрагдсан албан хаагчид 2024 оны 4 дүгээр сарын 10-наас 5 дугаар сарын 5-ны хооронд өөрсдийн байгууллагад хууль сурталчлах сургалтуудыг зохион байгуулж, бүх шатны боловсролын 60 байгууллага 100% хамрагдсан. Үүний үр дүнд нийт 7040 хүн, тэдгээрийн дотор 2561 багш, ажилтан (83.6%), 2545 эцэг эх, асран хамгаалагч, 1934 суралцагч сургалтад хамрагдсан. Мөн Юнител компанитай хамтран хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, багш нарын дунд идэвхжүүлэх уралдаан зарлаж, амжилттай оролцогчдыг шагнаж урамшуулсан. Энэхүү ажлын үр дүнд багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэж, боловсролын шинэчлэл бодитой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж чадсан.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.2.2 | Орон нутгийн удирдлагуудад шийдвэр гаргахад зөвлөмж, чиглэл өгөх, хамтран ажиллах | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Үзүүлсэн мэргэжил арга зүйн дэмжлэгийн тоо, үр дүн | 0 | Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 3 | Аймгийн засаг даргын захирамжийн төслийг төлөвлөж, Засаг даргын оролцох арга хэмжээний хөтөлбөр 5-г хянаж шийдвэрлүүллээ. "Хүүхдэд ээлтэй хүний хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж, сумуудын дотуур байрны дотоод нөхцөл байдал, тавилгыг шинэчилж, сурагчдын ая тухтай орчин бүрдүүлсэн. Сурагчийн ширээ, сандал шинэчлэгдэж, STEAM багц тоглоом худалдан авч, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, ур чадварыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжүүлэхэд дэмжлэг болсон. Мөн Боловсролын газарт шинэ автомашин шийдвэрлүүлж, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн. Энэ нь сурагчдын суралцах орчин, сургалтын чанарыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан. Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутгийн төсвөөр аймгийн 7 сургуулийн хүүхдүүдэд зориулан 45 суудалтай 3ш автобусыг шийдвэрлэсэн.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.2.3 | Хамран сургах тойрог тогтоох, мөрдүүлэх | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Хамран сургалтын хувь | Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт-86, бага боловсролын хамрагдалт - 95.6, суурь боловсролын хамрагдалт - 94.8 | Эхний хагас жилд: Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт -87, бага боловсролын хамрагдалт - 96.6, суурь боловсролын хамрагдалт -95.8 Жилийн эцэст: Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт -87, бага боловсролын | Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь заалт, Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/82 дугаар тушаалын дагуу Боловсролын газрын даргын 2024 оны А/24 дүгээр тушаалаар хамран сургах тойргийг шинэчлэн тогтоож тойргийн дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн элсэлтийг журмын дагуу зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: Ховд аймгийн ерөнхий боловсролын 24 сургуульд нийт 2124 сурагч 1 дүгээр ангид элсэж, сургуулийн өмнөх боловсролд 7332 суралцагч элссэн байна.<br>Хавсралт: 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдалт - 96.6, суурь боловсролын хамрагдалт -95.8 | | |
| 1.2.4 | Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх, хянах | Батлагдсан төсөв | Стандартын шаардлага хангасан гал тогоотой сургууль, цэцэрлэгийн тоо | Стандартын гал тогоотой цэцэрлэг-5, сургууль-4 | Эхний хагас жилд: Стандартын гал тогоотой цэцэрлэг-8, сургууль-10 Жилийн эцэст: Стандартын гал тогоотой цэцэрлэг-8, сургууль-10 | Ерөнхий боловсролын 24 сургуульд 10412 сурагч, сургуулийн өмнөх боловсролын 33 байгууллагад 6597 хүүхэд суралцаж байна. Сургуульд хоол үйлдвэрлэлийн 127, цэцэрлэгт 69 тогооч ажиллаж байна. 2024 оны 4-р сард орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн гал тогооны 310 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг сургууль, цэцэрлэгт, 6 дугаар сард улсын төсвөөс 68 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж шийдвэрлүүлж 14 сургуульд хуваарилсан. Ингэснээр нийт сургуулийн 65% нь тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. 2024 онд 3 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжид холбох ажил 70% гүйцэтгэлтэй байна.Төвлөрсөн усан хангамжид 13 сумын сургууль, цэцэрлэг 100% холбогдсон. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс санхүүжүүлэн Жаргалант сумын 6-р сургууль 11.3 сая төгрөгөөр засвар хийсэн, Прогресс сургууль 13.5 сая төгрөгийн төсөвтэй засварын ажил хийгдэж байна. Стандартын шаардлага хангасан гал тогоотой сургууль 22 буюу 76%, цэцэрлэг 28 буюу 76% эзэлж байна.<br>Хүрсэн түвшин: 100%<br>Хавсралт: 5 файл | 100% |
| 1.2.5 | Хоол шим тэжээлийн талаар сурталчлах, түгээх, зөвлөн | Батлагдсан төсөв | Зөвлөн тусалсан байгууллага, хоол, шим тэжээлийн | Зөвлөн тусалсан цэцэрлэг-23, сургууль-9, хоол | Эхний хагас жилд: Зөвлөн тусалсан цэцэрлэг- | 2024 оны 04 сарын 01-07 өдрүүдэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тогооч нарыг чадавхжуулах сургалтад 45 тогоочийг, мэргэшүүлэх зэрэг олгох сургалтад 24 сургууль, 25 цэцэрлэгийн эмч, дотоод хяналтын ажилтан нийт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | туслах | | сургалтад хамрагдсан иргэдийн тоо | үйлдвэрлэлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо -500 | 23, сургууль-25, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо -1000 Жилийн эцэст: Зөвлөн тусалсан цэцэрлэг-33, сургууль-25, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо -1500 | 40 хүнийг мөн чадвахжуулах сургалтад, "Хүүхдийн хоолны жор технологи, эрүүл ахуй" сургалтад -74, Нарийн боовны үйлдвэрлэл" сургалтад 36 нийт 216 тогоочийг сургалтад тус тус хамруулав. Ерөнхий боловсролын 11 сургууль, 20 цэцэрлэг, 4 сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр зөвлөн тусалж ажиллав. Туршлага солилцох уулзалтад 85 тогооч оролцов. Баруун бүсийн сургууль цэцэрлэгийн тогооч нарын ур чадварын уралдааны 2-р шатанд 5 тогооч шалгарснаас 3 тогооч 1, 2-р байр эзлэв. Шим тэжээлийн боловсрол нөлөөллийн аяны хүрээнд нийт 4236 эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн 2640 суралцагч, 2475 сурагч, туршлага солилцох уулзалтад 85 тогооч, 3 түвшиний хичээлийг эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 20800 сурагчид мэдлэг олгосон, нийт 5000 брошур, 27 видео бичлэг хийж олон нийтэд түгээсэн байна. 24 сургууль, 7 дотуур байр, 25 цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчинд хяналт хийж байна. 2024 оны 5 дугаар сард хүүхдийн хоолны зөвлөл дэх 5 байгууллагын хамтарсан хяналтыг 7 сургууль, 16 цэцэрлэгт мөн Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад,Буянт, Мөст, Алтай, Үенч сумын сургууль, цэцэрлэгт хяналт хийж зөвлөн туслав. Сургуулийн хүүхдийн хоолонд хяналт тавих багш, сурагч, эцэг эхийн төлөөлөл гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус хяналтын зөвлөлийг 24 сургуульд байгуулж хяналт хийн хоол үйлдвэрлэлийн стандарт, бодлого, дүрэм журмыг танилцуулж, хэрэгжилтийг хангахад шаардлагатай онол арга зүйн дэмжлэг үзүүллээ. Сургууль, цэцэрлэгийн эмч нарт хоол үйлдвэрлэл болон шимт тэжээлийн талаарх зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч байх чиглэл өгч ажилласаны хүрээнд сургууль, цэцэрлэгийн орчинд эцэг эх, багш нарт сургалт зохион байгуулж хоолны үзэсгэлэн гаргасан.<br>Хүрсэн түвшин: Зөвлөн тусалсан цэцэрлэг-33, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургууль-25, 8 дотуур байр. Сургалтад 20800 сурагч, 4236 эцэг эх, асран хамгаалагч сургалтад хамруулав.<br><br>Хавсралт: 5 файл | |
| 1.2.6 | Сургалтын хэрэглэгдэхүүн болон сурах бичиг, гарын авлага, цахим хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Батлагдсан төсөв | Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангалтын хувь | 96 | Эхний хагас жилд: 97.5 Жилийн эцэст: 98 | Бага ангийн сурах бичгийн хангалт 98,6%, дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт 98,8% -тай байна. 2024-2025 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн 18715 ширхэг сурах бичиг, 6-12 ангийн 2206 багц сурах бичгийг сурагчдад ашиглуулж сурах бичиг дутагдалтай байгаа сургуулиудын 6-12 ангийн сурагчдад Эй плайс ХХК-ний худалдааны сурах бичгийг нэмэлтээр авч түрээсээр ашиглуулж байна.<br>Хүрсэн түвшин: Сурах бичгийн хангалт 100 хувьд хүрсэн<br><br>Хавсралт: 1 файл | 100% |
| 1.2.7 | Боловсролын баримт бичиг олгох | Батлагдсан төсөв | Олгосон боловсролын баримт бичгийн тоо | 2973 | Эхний хагас жилд: 160 Жилийн эцэст: 2670 | Ховд аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг төгсөж буй суурь боловсрол -1822, бүрэн дунд-1265, "Хөгжил" политехник коллежийг мэргэжлийн диплом-83, мэргэжлийн үнэмлэх-357 бичиг баримт олгосон. 2024 онд нөхөн олголтоор суурь болон бүрэн дунд боловсролын нийт 39 бичиг баримт олгосон байна.<br>Хүрсэн түвшин: Нөхөн олголтоор олгож буй боловсролын баримт бичгийн материалыг бүрэн бүрдүүлэн авч архивын баримт болгон хадгалж байна. | 100% |
| 1.2.8 | Статистик тайлан мэдээ гаргах, нийтэд хүргэх | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Статистик, тайлан мэдээллийн тоо | СӨБ албан ёсны 8 маягт, захиргааны мэдээллийн 9 БДБ-ын | Эхний хагас жилд: СӨБ албан ёсны 8 маягт, захиргааны | 2024 оны 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд намрын статистик тайлан мэдээг ерөнхий боловсролын 25 сургууль, насан туршийн 2 боловсрол төвөөс 5 асуулгын нийт 53 маягтаар, төрийн өмчийн 33 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 37 байгууллагаас 3 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албан ёсны 10, захиргааны мэдээллийн 75 | мэдээллийн 9 БДБ-ын албан ёсны 9, захиргааны мэдээллийн 62 Жилийн эцэст: СӨБ албан ёсны 8 маягт, захиргааны мэдээллийн 9 БДБ-ын албан ёсны 10, захиргааны мэдээллийн 75 | асуулгын 18 маягтын дагуу захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг гаргуулж өмнөх жилийн мэдээтэй харьцуулж тайлбар авч, бодит байдалтай зөрүүтэй гэж үзсэн тоон мэдээлэлд тайлбар, залруулга хийлгэж мэдээний хугацаанд тайлагнаж дээд шатны байгууллагад мэдээллийг гарган хүргүүллээ. Хүрсэн түвшин: Статистик тайлан мэдээнд нийт 64 байгууллага хамрагдлаа. | |
| 1.2.9 | Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн системыг бүрдүүлж, хөгжүүлэх | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Боловсролын удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлсэн сургалтын байгууллагын тоо | 19 | Эхний хагас жилд: 25 Жилийн эцэст: 25 | 2023-2024 оны хичээлийн жилд боловсролын багц хууль батлагдсантай холбоотойгоор боловсролын салбарын мэдээллийн системийн маягтуудад өөрчлөлт орсон. Байгууллагууд мэдээ тайланг системийн заасан хугацаанд бүрэн гаргаж хянуулж ажиллаж байна. Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем болох esis.edu.mn -ийг тогтмол ашиглаж тайлан мэдээллийг боловсруулж байна. Сургалтын удирдлагын болон боловсролын удирдлагын Их нүүдэл системийг Ховд аймгийн 23 сургууль үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Бүх сургууль, цэцэрлэг esis.edu.mn системийг ашиглан тайлан мэдээллээ боловсруулж 23 сургууль Их нүүдэл системийг ашиглан сургалтын болон удирдлагын мэдээллийн системийг ашиглаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. 10 | Авлига авах, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн иргэдийн тоо | ХАСУМ - 5 ХАСХОМ-69 | Эхний хагас жилд: ХАСУМ - 10 ХАСХОМ-172 Жилийн эцэст: ХАСУМ - 15 ХАСХОМ-190 | Ховд аймгийн Боловсролын газар нь 7 хоног бүрийн Лхагва гарагт боловсролын сургалтын байгууллагын удирдах албан тушаалтнуудад цахим хурлыг зохион байгуулж хэвшсэн. 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн цахим хурлаар ХАСУМ болон ХАСХОМ-ыг шинээр мэдүүлэхэд мэдүүлэг гаргагч албан тушаалтнууд хэрхэн мэдүүлэх талаар, ХАСХОМ бүртгүүлсэн 52 албан тушаалтан /цэцэрлэгийн аргазүйч, сургалтын менежер, сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч/-д ХАСХОМ-ыг хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар зөвлөгөө өгч ажилласан. 2024 оны 02 сарын 14-ны өдөр Боловсролын газрын ЭБАТ, салбарын байгууллагын 49 албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад тусгагдсан эрх, үүрэг, хориглолт, ХАСУМ, ХАСХОМ-ын талаарх мэдээллийг хүргэж ажилласан. Боловсролын газрын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 12 албан хаагч, Боловсролын сургалтын байгууллагын 23 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Ховд аймгийн хэмжээнд боловсролын салбарт ажилладаг удирдлагын түвшний 195 хүний хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгийг хуулийн хугацаанд бүрэн хянаж, баталгааны маягтаар баталгаажуулан холбогдох тайлан мэдээг авилгатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан. | 100% |
| 1.3. | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах | Улсын болон батлагдсан төсөв | Арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ тус бүрийн суурь түвшин | Арга хэмжээ тус бүрийн суурь түвшин | Тайлант хугацаанд хэрэгжиж буй "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III", "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих" үндэсний хөтөлбөрүүдийн зорилтуудыг хяналтад авч байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусган хэрэгжүүлж ажиллаж байна. | |
| 1.3.1 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Батлагдсан төсөв | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 90 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ зохион байгуулж гүйцэтгэл 9306% биелэлттэй байна. Ховд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 24 сургуульд I-V ангид нийт 10412 сурагч” Үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна.. аймгийн 20 сургуулийн 6-12 дугаар ангийн 5748 сурагчдыг эцэг эхийн дэмжлэгтэйгээр үдийн хоол хөтөлбөрт хамруулаад байна Шим тэжээлийн боловсрол нөлөөллийн аяны хүрээнд нийт 4236 эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн 2640 суралцагч, 2475 сурагч, туршлага солилцох уулзалтад 85 тогооч, хүүхдийн хоолны шим тэжээлийн талаар 3 түвшний хичээлийг эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 20800 сурагчид мэдлэг олгосон. Нийт 5000 брошюр, 27 видео бичлэг хийж олон нийтэд түгээсэн байна. -Эмч нарыг чадваржуулах цахим, танхимын нийт 9 удаагийн, тогооч нарыг чадавхжуулах 5 удаагийн танхимын сургалт зохион байгуулсан . -Ерөнхий боловсролын 9 сургуулийн хоол үйлдвэрлэлийн ARTA систем нэвтрүүлэн программ болон киоск машин суурилуулан, сургалт арга хэмжээ зохион ажиллаж байна<br>Хүрсэн түвшин: 93,6<br>Хавсралт: 4 файл | 100% |
| 1.3.2 | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3-ийг хэрэгжүүлэх | Батлагдсан төсөв | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70 | Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 85 | Төрийн байгууллагууд гадна хосолсон жижиг хаяг, том гэрэлт хаягтай, дотно өрөө тасалгаа, мэдээллийн самбараа хос бичгээр бичиж хаягжуулан, монгол бичгийн орчин бүрдүүлж тохижуулсан. Аливаа шагнал урамшууллыг монгол бичгээр хослуулан бичиж хэвшсэн. Уран бичлэгийг сонирхогчдын тоо нэмэгдэн, бийрийн дугуйлан, сургалтад давхардсан тоогоор 500 орчим сурагч, иргэд хамрагдсан. Төрийн байгууллагын архив | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичиг хэргийн ажилтнуудад үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, албан хэргээ хос бичгээр бичиж туршиж эхэлсэн “Хос бичигтэн Ховдчууд” цахим хуудсаар дамжуулан монгол бичигтэй холбоотой бичвэр байршуулснаас гадна мэдээ, мэдээлэл, зохион байгуулж буй үйл ажиллагааны явц, хэрэгжилтийг сурталчиллаа. Үндэсний бичиг үсгийн баярыг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Соёл урлагийн газар, Хэлний салбар зөвлөл хамтран жил бүр тодорхой уриан дор зохион байгуулж, аяны хүрээнд зохион байгуулж буй үйл ажилаагааны ангилал, оролцогчдын тоо,  нэмэгдсэн. Монгол бичгээ сурах түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилгатай ажилласан 5 байгууллагыг алдаршуулан контент бүтээсэн. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаарх контент хийж түгээлээ. Бийрийн дугуйлан хичээллүүлэн үзэсгэлэн гаргалаа. Шилдэг сум шалгарууллаа.Монгол Улсын Засгийн газрын шагнал “Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэгч” тэмдгээр Мөнххайрхан сумын МХБУЗ-ын багш З.Нарантуяа, Ц.Отгонхишиг, 1-р сургуулийн багш Д.Эрдэнэчимэг нар шагнагдлаа.  Аймгийн “Чадварлаг багш”-аар бага ангийн 3 /Р.Алимаа, М.Цэндсүрэн, Даваасум/, монгол хэлний 2 багшийг /Г.Сарнай, С.Болор/ тус бүр 4.0 сая төгрөгөөр урамшууллаа.<br>Хүрсэн түвшин: 87.5<br>Хавсралт: 6 файл | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 3.1. | Боловсролын ерөнхий хуулийн 28.2 дахь чиг үүргийг | Улсын болон батлагдсан төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлтүүд | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | Тус зорилтын хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хханган ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх | | | | | | |
| 3.1.1 | Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Хууль тогтоомжийн хэрэгжилийг ханган ажилласан байгууллагын тоо | 60 | Эхний хагас жилд: 60 Жилийн эцэст: 60 | Эхний хагас жилд боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд улиралын амралтыг хугацаанд зохион байгуулж, улиралын хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд хангаж ажилласан. Цаг агаарын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр өвөлжилт хүндэрсэн Булган, Алтай, Үенч сумдын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд тогтмол зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвөөс гаргасан журам, дүрэм, аргачлал, чиглэлийг хяналтад авч харьяа байгуулагад хүргэн арга зүйн удирлагаар ханган тогтмол ажиллаж байна. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-д "Хүүхдийн хоол тэжээлийн шимт дэмжлэг" хөтөлбөрийг батлуулан бага насны хүүхдүүдэд 7 хоногийн 2 өдөрт 200гр сүү олгож байна. Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарын 87 хувийг компьютержүүлж, цэцэрлэгийн багш нарыг таблетээр хангаж, ерөнхий боловсролын сургуулийн дотоод сүлжээний орчинг сайжруулах тендерт бүх сургуулийг хамруулж, 11 сургууль цахим кабинетийг захиалж цахим шилжилтийн суурь нөхцлийг бүрэн бүрдүүлж ажиллаж байна. Дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, судалгаа, мэдээ мэдээллийг тогтмол хугацаанд гаргаж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Салбарын 60 байгууллага хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.1.2 | Сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны | Тусгай зөвшөөрөл олгосон, цуцалсан байгууллагы | 58 байгууллагын тусгай зөвшөөрөл олгосон, 2 | Эхний хагас жилд: 2 байгууллагын тусгай | БШУ-ны сайдын 2024 оны А/28 тушаалын баталсан аргачлалын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нэршлийг шинэчлэн аймгийн Засаг даргын 2024 оны А/158 дугаар захирамж гаргуулж уг захирамжын хүрээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт хийх | зардал | н тоо | байгууллагын тусгай зөвшөөрөл цуцалсан | зөвшөөрөл олгох, 1 байгууллагын тусгай зөвшөөрөл цуцлах Жилийн эцэст: 2 байгууллагын тусгай зөвшөөрөл олгох | нэршилд өөрчлөлт орсон 6 сургуулийн тусгай зөвшөөрөлд нэршил өөрчилсөн тухай тэмдэглэл хийлгэж, БШУ-ны сайдын 2024 оны А/28 тушаалаар орон нутгийн өмчлөлд шилжсэн Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн нэршил өөрчилж, тусгай зөвшөөрөл олгох тухай аймгийн засаг даргын 2024 оны А/30 дугаар захирамжийн дагуу тусгай зөвшөөрлийг шинэчлэн олголоо. 2024 онд шинээр ашиглалтад орсон Булган сумын 3-р цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг цахим системээр анх удаа олгох ажлыг зохион байгуулж Боловсролын яаманд мэдээллийг хүргүүлж хамтран ажиллаваа.<br>Хүрсэн түвшин: 2 сургуулийн тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгож, 6 байгууллагын тусгай зөвшөөрөлд нэршил өөрчилсөн тэмдэглэл хийлээ. | |
| 3.1.3 | Сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах | Батлагдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв | Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан сургалтын байгууллагын тоо | 25 | Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 60 | Сургуулийн менежментийг дэмжих, зөвлөн туслах ажлыг Боловсролын ерөнхий газартай хамтран 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулж ажилласан. Энэ ажлын хүрээнд Жаргалант сумын Цаст-Алтай, 1, 3, 6 дугаар сургуулиуд, Буянт, Мянгад, Мөст, Мөнххайрхан сумын сургуулиудад сургуулийн өөрийн үнэлгээ хийх аргачлал, сургуулийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд зөвлөн тусалж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад буюу ээлжит хичээлд ажиглалт хийж ажилласан. Энэ хүрээнд БШУГ-ын судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд болон бусад мэргэжилтнүүд өөр өөрийн чиглэлийн дагуу зөвлөгөө өгч ажилласан. Тус үйл ажиллагааны хүрээнд судлагдахуун хариуцсан 6 мэргэжилтэн 6 сургуулийн 24 багшийн хичээлд ажиглалт хийж 530 гаруй багш, удирдлага, эцэг, эх иргэд олон нийт, суралцагчидтай уулзалт хийж ажилласан. Мэргэжилтнүүдийн сургууль, цэцэрлэг дээр ажиллах 1 өдрийн хуваарь гаргаж мөрдүүлж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байгаа бөгөөд судлагдахуун хариуцсан 6 мэргэжилтэн, сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн нар 350 багшийн хичээлд ажиглалт хийж, зөвлөмж өгч ажилласан. Жаргалант сумын I,II,III,VI,VII,Прогресс,Цаст-Алтай,Эрдэнэбүрэн, Буянт,Булган сумын Минжит булган цогцолбор сургууль,Мөст,Ховд, Мөнххайрхан,Алтай үэрэг сургуулиудад сургууль төвт зөвлөх үйлчилгээ үзүүлсэн<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.1.4 | Насан туршийн боловсролын төвүүдтэй хамтран ажиллах, зөвлөн туслах, иргэдэд насан туршийн боловсролын үйлчилгээ үзүүлэх | Батлагдсан төсөв | Насан туршийн боловсролын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 1821 | Эхний хагас жилд: 1900<br>Жилийн эцэст: 2000 | Ховд аймгийн хэмжээнд насан туршийн боловсролын 2 төв үйл ажиллагаа явуулж байна. Булган сумын насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаатай ахлах мэргэжилтэн Д.Батнасан, статистик-хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Батсайхан нар 2024 оны 04 сарын 29-нд танилцаж үйл ажиллагааны төлөвлөлт, сургалтын хөтөлбөрт зөвлөмж өгч ажиллав. Жаргалант сумын Насан туршийн төвийн захирал, сургалтын менежер нарт мэдээллийн систем ашиглах, хэрэгжүүлэх талаар тогтмол зөвлөгөө өгч ажиллан насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, сурталчилах чиглэл өгч ажилласан. Монголын багш нарын 8-р их хуралд насан туршийн боловсролын төвийн багш С.Батцэцэг сонгогдон оролцлоо. 2024 оны 11 сарын 06, 07 өдрүүдэд Ховд аймагт баруун бүсийн Насан туршийн багш, удирдах ажилтан, хүний нөөцийг чадваржуулах 2 өдрийн сургалтыг БЕГ, Ховд аймгийн Насан туршийн төв хамтран зохион байгууллаа. Сургалтанд Увс, Баян – Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Ховд гэсэн 6 аймгийн 134 багш, удирдах ажилтан хамрагдлаа.<br>Хүрсэн түвшин: Насан туршийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж амьдрах ухааны болон иргэдийн боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амжилттай хэрэгжүүлж байна.<br>Хавсралт: 3 файл | |
| 3.1.5 | Сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохирох орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | Батлагдсан төсөв | Сургалтын орчны аюулгүй байдлыг хангасан сургалтын байгууллагын тоо | 60 | Эхний хагас жилд: 60<br>Жилийн эцэст: 60 | Сургууль, цэцэрлэг бүр БШУЯ-ны хоол үйлдвэрлэлийн нэгдсэн систем дээр өдөр бүр мэдээлэл оруулснаар бүх шатанд цахимаар хянах, үнэлэх боломжтой. Ерөнхий боловсролын 9 сургуульд хоол үйлдвэрлэлийн ARTA систем нэвтрүүлэн, программ болон киоск машин суурилуулж сургалт арга хэмжээ зохион ажиллаж байна. Хүнсний хангамжийг байгууллага бүр тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, эрүүл ахуй, чанар аюулгүй байдлыг сахин, мэргэжлийн байгууллагын шинжилгээ хийлгэх ажилд хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн үйлдвэрлэгч нарын үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэж байна. - 2024 оны байдлаар төсөв санхүүгийн болон, хоол хүнсний хангамж, ариутгал халдваргүйжилтийн бодисын дутагдалгүйгээр хичээл үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүллээ. Сургалтын байгууллагуудын байр ашиглалтыг 100 ашиглаж сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгууллаа. 2024 оны 1 дүгээр сард Жаргалант сумын 6 дугаар сургууль, 9 дүгээр сарын 1-нээс 2 дугаар сургууль үдийн хоол үйлдвэрлэж эхэлснээр аймгийн бүх сургууль 100% хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлээд байна. - 5 сумын ариун цэврийн байгууламжийг улсын комисс хүлээн авлаа. Үүнд: Мянгад, Эрдэнэбүрэн, Чандмань, Буянт, Дарви сумдад улсын комисс ажиллаа. Ховд сумын ариун цэврийн байгууламж 90%-тай хийгдэж байна. 2024-2025 онд 4-р ээлжийн ариун цэврийн байгууламж хийгдэх Манхан, Дөргөн, Булган 1-р цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажлын явц 50-70% үргэлжилж байна. Ингэснээр Ховд аймагт 100% ариун цэврийн байгууламжтай болж сургалтын орчны аюулгүй байдал, хөгжлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй хүүхдийн тохирох сургалтын орчин бүрдэж байна.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.1.6 | Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх, үнэлэх,зөвлөх үйлчилгээ үзүүлэх | Батлагдсан төсөв | Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн хувь | 60 | Эхний хагас жилд: 70<br>Жилийн эцэст: 80 | Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулсан сургуулийн нийгмийн ажилтануудыг чадваржуулах сургалтад 15 сургуулийн 23 нийгмийн ажилтан хамрагдаж үнэлгээ хийх арга зүйд суралцлаа. Ингэснээр сургууль тус бүр хүүхэд хамгааллын бодлогын өөрийн үнэлгээ хийж дүгнэхэд аймгийн хэмжээнд өөрийн үнэлгээний хэрэгжилт 75% хэрэгжиж байгаад анхаарал хандуулж сургуулийн удирдлага, сургуулийн нийгмийн ажилтнуудад үүрэг чиглэл өгч ажилласан. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төсөв санхүүгийн хувьд зарцуулалт дунджаар 70% зарцуулалттай байна. Үүнээс 2 сургууль 90% дээш зарцуулсан бол 22 сургууль 40-өөс дээш хүртэл хувь зарцуулсан байна.<br>Хүрсэн түвшин: 90 | 100% |
| 3.1.7 | Сургалтын байгууллагын гамшгийн эрсдлийг үнэлэх, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, нөхцөл байдлыг тогтворжуулахад хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээ авсан байгууллагын тоо | 25 | Эхний хагас жилд: 40<br>Жилийн эцэст: 60 | Хүний папиллома вирусын халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах бэлэн байдлыг хангах нь" сэдэвт чадавхжуулах сургалтад сургуулийн захирал, эмч нийт 48 хүнийг хамруулав. Тус дархлаажуулалтад 2024 оны 12 дугаар сарын байдлаар 499 сурагч хамрагдаад байна. Сургууль, цэцэрлэгийн 30 эмч, эрүүл мэндийн багшийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, улаанбурхан улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын бэлтгэл ажлын талаар ЭМГ-ын сургалтын танхимд сургалтад хамруулав. Тус дархлаажуулалтад 1160 багш хамрагдаад байна. Цаг агаарын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр өвөлжилт хүндэрсэн Булган, Алтай, Үенч сумдын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд тогтмол зөвлөмж, чиглэл өгч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан. Гамшиг онцгой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу нийт сургууль цэцэрлэгүүд эрсдлийн үнэлгээ хийсэн байна. Гамшиг, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд гамшиг, онцгой байдлын үед сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй зохион байгуулах нөхцлийг хангах, чиглэлээр мэдээлэл, зөвлөмжийг сургууль, ,цэцэрлэгүүдэд хүргэж ажиллаж байна. Сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр Улсын төсвөөс- 12,205.400 , орон нутгийн сангаас- 381.067.454, хандив тусламжаар - 95.530.000 төгрөгийн төсөв шийдвэрлүүлж сургалтын орчны аюулгүй байдлыг ханган ажиллав. Онцгой байдлын үед хэрхэн яаж, өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх, гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн дадлага сургалтыг эцэг эх-288 , 234 багш, 5787 сурагч оролцов. Сургууль, анги, танхим, коридор, гадна талбайг камержуулан, цахилгааны утаснуудаа далдалж, галын аюулгүй байдлын булан, онцгой байдлын үед гарах аюулгүй гарц, план зургийг сургууль болон дотуур байранд байршуулсан.<br>Хүрсэн түвшин: 100% Боловсролын салбарыйн 60 байгууллага гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан | |
| 3.1.8 | Сургалтын байгууллагын багш, ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг | Батлагдсан төсөв | Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамрагдагсадын тоо | 456 | Эхний хагас жилд: 1000<br>Жилийн эцэст: 1500 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу 24 сургууль, 33 цэцэрлэгт ёс зүйн дэд хороо байгуулсан мэдээллийг сургууль, цэцэрлэгүүдээс авч нэгтгэж Боловсролын ерөнхий газар болон төрийн албаны зөвлөлд хүргүүллээ. Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн дэд хорооны 139 гишүүн, 33 цэцэрлэгийн ёс зүй дэд хорооны 136 гишүүдийг төрийн албаны зөвлөлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах | | | | | цахим сургалтад хамруулж албан хаагч ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн дэд хорооны гишүүд цэцэрлэг, сургуулийнхаа 1200 гаруй багш нарыг 3 удаагийн цахим сургалтад хамруулсан байна. Аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн хууль зүйн хэлтэстэй хамтран сургууль цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүн нийт 174 хүнд сургалт зохион байгуулав.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.1.9 | Зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Зайн болон цахим сургалтын үр чадвар эзэмшсэн багш нарын хувь, өгсөн мэргэжил арга зүйн дэмжлэгийн тоо | 20% | Эхний хагас жилд: 30%<br>Жилийн эцэст: 50% | Бага ангийн математикийн сургалтын чанарыг сайжруулах eduten цахим сургалтад 1-5 дугаар ангийн 62 бүлгийн 1898 сурагч, 4 дүгээр ангийн 2042 сурагч хамрагдлаа. 3, 4 дүгээр ангийн 128 багшийг 1 удаа танхим, 3 удаа цахим сургалтад хамруулж арга зүйн дэмжлэг үзүүллээ. 3, 4 дүгээр ангийн eduten сургалтын хөтөлбөрийн цахим гэрээ байгуулах талаар сургуулийн захирал, нягтлангуудад сургалт зохион байгуулж цахим гэрээ байгууллаа. 1,2,5 дугаар ангийн сурагчдыг бүртгэх талаар мэдээлэл хийж багш нараа сурагч эрхээр бүртгэж цахим сургалтад хамруулж байна. 9 сургууль eduten сургалт зохион байгуулах бага ангийн цахим кабинет байгуулсан бусад сургууль дунд ангийн МХТ-ийн ангид сургалтаа зохион байгуулж явуулсан байна. Багш нар арга зүй туршлагаа eduten mongolia, Ховд бага боловсрол цахим хаягт байршуулж туршлагаа солилцлоо. Ерөнхий боловсролын 24 сургуулийн 48 цахим танхимд Англи хэлний Пэйрсон хөтөлбөрт 5-6 р ангийн 4098 сурагч, Жаргалант сумын Цаст-Алтай, Мянгад сургуулийн 7,10-р ангийн 369 сурагч хамрагдлаа. Бага ангийн Eduten хөтөлбөрт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3,4-р ангийн 3940 сурагч хамрагдаж байна. Цахим системд суурилсан англи хэлний Пэйрсон хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой цахим гэрээ байгуулах, лицензийн төлбөр төлөх заавар аргачлалыг сургуулиудад хүргэн, мэдээллээр ханган, 100 хувь гэрээ байгуулан, төлбөрийг бүрэн хийлгэлээ. https://www.facebook.com/Khovd.BSHUG/videos/314675145014884<br>Хүрсэн түвшин: Хүрсэн түвшин: 40%,Бага ангийн 128 багш, гадаад хэлний 72 багш | |
| 3.1.10 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай хамтран зохион байгуулах, үр дүнг үйл ажиллагаанда а тусган мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, үр дүнг | Батлагдсан төсөв | Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо, гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Цэцэрлэг-88,7, сургууль-73 | Эхний хагас жилд: Цэцэрлэг-89, сургууль-74 Жилийн эцэст: Цэцэрлэг-89, сургууль-74 | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам, БШУ-ны сайдын 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаалын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах чиглэлийн дагуу 4-р сарын 16-с эхэлж бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээг 4 дүгээр сарын 29-нээс 5 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. 25 сургуулийн 921 багш давхардсан тоогоор 25800 сурагчид хамрагдаж. Нийт үнэлгээнд хамрагдах ёстой багш нарын 99%, сурагчдын 92,2% хамрагдсан байна. Сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэлийн үнэлгээнд 2024 оны 04.15-20 ны хооронд орон нутгийн өмчийн 33 цэцэрлэгийн бүлгийн 194 багш, 27 хөгжмийн багш, 2-5 насны 2874 хүүхдээс 2714 буюу 94 хувь, хөгжмийн 995 хүүхдээс 913 хүүхэд буюу 92% хамрагдсан байна. Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 25 байгууллага үнэлэгдэж 21 аймгаасаа 81.16 оноотойгоор тэргүүлж өмнөх оноос 8 оноогоор ахисан амжилт үзүүлэв. Сургуулиудаас 1 дүгээр түвшинд -5,2 дугаар түвшин-4, 3 дугаар түвшин 8, 4 дүгээр түвшинд 1 сургууль дүгнэгдэж нийт сургуулийн 72% нь үр дүнгийн мөнгөн урамшуулал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнах | | | | | авахаар эрх авлаа. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээд 985 багш оролцож нийт багш нарын 61% нь үр дүнгийн урамшуулалд хамрагдана.Сургуулийн өмнөх боловсрол 91,76 % үнэлэгдэж улсад II үнэлэгдсэн. Орон нутгаас I-III түвшинд үнэлэгдсэн байгууллага тус бүрийн багш хөгжлийн төвийг тохижуулах санхүүжилтийг шийдвэрлэж олгосон.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 3.1. 11 | Боловсролын үнэлгээний төвтэй хамтран элсэлтийн ерөнхий шалгалт, чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулах | Батлагдсан төсөв | Элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дундаж оноо | 503,8 | Эхний хагас жилд: 510 Жилийн эцэст: 510 | 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Боловсролын үнэлгээний төвөөс баталсан 2024 оны элсэлтийн журмын дагуу онлайн бүртгэл 04 сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилсэн. Тус бүртгэлд бүртгүүлэх явцад зөвлөмж мэдээлэл шаардлагатай болсон иргэдэд утсаар 52 удаа, биечлэн 23 удаагийн заавар зөвлөмж өгч, 17 хүүхдийн бүртгэлийг хийж өгч ажилласан. Мөн бүртгэлийн хугацаа, бүртгэл хийлгэхэд шаардлагатай мэдээллийн талаар ерөнхий боловсролын сургуулиудад 2 удаагийн зөвлөмж мэдээлэл хүргэж, БҮТ-ээс гаргасан цахим мэдээллийг 13 удаа хуваалцсан. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцагчдын эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёл, эх хэлний дархлааны түвшин тогтоох МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ 2024 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр БҮТ-ийн 2 мэргэжилтэн, зохион байгуулагч 10, хянагч багш 64 хүний бүрэлдэхүүнтэйгээр Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 32 анги танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Нийт 1030 төгсөгч бүртгүүлснээс 980 нь буюу 95.1% ирцтэй хамрагдлаа. 2024 оны элсэлтийн шалгалтад 1061 шалгуулагч өгөхөөр бүртгүүлснээс 127 нь өмнөх оны төгсөгч, 934 нь энэ оны төгсөгч байна. Элсэлтийн шалгалтыг 2024 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 7-р сарын 4-9-ны өдрүүдэд 10 зохион байгуулагч, 44 хянагч багшийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгууллаа. Элсэлтийн шалгалтын оноог дээшлүүлэх, бэлтгэлийн явцад хяналт тавих зорилгоор 8 удаагийн сорил шалгалт зохион байгууллаа. 8 шалгалтын анхны онооны дундаж гүйцэтгэл 31,2 байгаа нь өмнөх оны сорилын дундажтай ойролцоо байна. Өвлийн элсэлтийн шалгалтад 236 шалгуулагч хамрагдсан.<br>Хүрсэн түвшин: 507.8<br>Хавсралт: 1 файл | |
| 3.2. | Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах, боловсролын сургалтын байгууллага, багш, ажилтан, иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Улсын болон орон нутгийн хөгжлийн сангаас батлагдсан төсөв | Арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ тус бүрийн суурь түвшин | Арга хэмжээ тус бүрийн зорилтот түвшин | Энэ зорилтын хүрээнд 5 арга хэмжээг төлөвлөн амжилттай хэрэгжүүллээ. | 100% |
| 3.2.1 | Ажил мэргэжлийн чиг баримжааг сурталчлах, төрөлжсөн болон сонгон суралцах | Батлагдсан төсөв, үйл ажиллагааны зардал | Сонгонд суралцаж буй ахлах ангийн сурагчдын хувь, ажил мэргэжлийн | Сонгоны бүлэгт 55, ажил мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд | Эхний хагас жилд: Сонгоны бүлэгт 55, ажил мэргэжлийн дэмжлэг | Энэ хичээлийн жилд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг 201 удаа зохион байгуулж, 25 сургуулийн 6693 сурагчийг хамруулсан. Иргэд олон нийт төрийн бус байгууллагатай хамтран 10 сургалтанд 3620 сурагч хамрууллаа. Эцэг эхэд зориулсан 57 үйл ажиллагаанд 6331 эцэг эх хамрагдлаа. Тусгай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт зохион байгуулах үйл ажиллагааг сайжруулах, | | дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан ахлах ангийн сурагчдын хувь | хамрагдсан дунд, ахлах ангийн сурагчдын хувь 50 | үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан дунд, ахлах ангийн сурагчдын хувь 70 Жилийн эцэст: Сонгоны бүлэгт 55, ажил мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан дунд, ахлах ангийн сурагчдын хувь 90 | хэрэгцээт сурагчдын 11 сургалтанд 89 сурагч хамрагдлаа. Мэргэжлийн онцлогт тохирсон мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээлэл өгч, мэргэжил эзэмшүүлэх ажлыг тогтмолжуулан тодорхой үр дүнд хүрсэн байна.Ахлах ангийн сурагчид 100% хамрагдлаа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 3 файл | |
| 3.2.2 | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлэх | Батлагдсан төсөв | Хөгжлийн ялгаатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 10 | 2024 оны хичээлийн жилд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлттэй 315 хүүхэд байгаагаас 63 хүүхэд насан туршийн боловсрол төвд, 172 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, 23 -цэцэрлэгт хамрагдаж байна. Тусгай хэрэгцээт, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй 251 хүүхэд байгаагийн 79.6 хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Нэгдүгээр ангид элсэн суралцах хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй 21 хүүхдийн судалгаа гаргаж эцэг эх, багш нарт мэдээлэл, зөвлөмж хүргэж ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэг үндэсний хэмжээнд, Зэрэг сумын цэцэрлэг, Жаргалант | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумын 12 дугаар цэцэрлэгийн туршлагыг баруун 5 аймгийн хүрээнд танилцуулж ажиллалаа. Зэрэг сумын цэцэрлэг, Жаргалант 9 дүгээр цэцэрлэгийн багш нарын арга зүйг дэмжих, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан 12 сая төгрөгийн хэрэглэгдэхүүнийг Японы Жайка төслөөс олголоо. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд хамруулж буй 24 сургуулийн дэмжлэгийн багийн гишүүдийг чадваржуулах сургалтад багийн ахлагч нар хамрагдлаа. 3, 7 дугаар сургуулийн хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй ментор багш нар арга зүйгээ түгээлээ. Хөгжлийн ялгаатай хэрэгцээт хүүхдийн орчин бүрдүүлэхэд анхаарч цэцэрлэгийн багш нарыг Улаанбаатар хотын сувиллын 10 дугаар цэцэрлэг, сургуулийн багш нарыг Улаанбаатар хотын 16 сургуульд туршлага судлууллаа. Нийт 4 төрлийн сургалтад 98 багш хамрагдлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд сууж 32 эцэг эх, 23 багшид арга зүйн дэмжлэг үзүүллээ.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.2.3 | Хичээлээс гадуурх суралцагчийн хөгжил, авьяасыг хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, бусад байгууллагатай хамтран ажиллах | Батлагдсан төсөв | Хичээллэсэн сонгон дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо | 231 дугуйланд 7319 сурагч | Эхний хагас жилд: 231 дугуйланд 7500 сурагч Жилийн эцэст: 231 дугуйланд 800 сурагч | 2024-2025 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 25 сургуулиас зохион байгуулж байгаа 13 төрлийн секц, дугуйланд 14202 сурагч, сургуулиас гадуур төлбөртэй 22 төрлийн секц, дугуйланд 646 сурагч суралцаж байна. Боловсролын ерөнхий газар нь After School платформоор дамжуулан 74 сурагч цахимаар секц, дугуйланд хамрагдсан байна.Ахлах ангийн суралцагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, нөлөөллийн 123 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд давхардсан тоогоор 15279 суралцагч хамрагдсан байна. 2024-2025 оны хичээлийн жилд Ерөнхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын 25 сургуульд After School платформ амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд БЕГ-аас БГ-ын мэргэжилтэн болон Сургуулийн Нийгмийн ажилтангуудад 2 удаагийн сургалт зохион байгуулсан. After school системийн А онооны цахим сургалтад сурагчид хуваарийн дагуу хамрагдаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.2.4 | Цахим сургалтын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын байгууллагын цахим дэд бүтэц, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, оновчтой зохион байгуулах чиглэлээр зөвлөмж өгөх, дэмжих | Батлагдсан төсөв | Цахим сургалтын дэд бүтцээр хангагдсан сургалтын байгууллагын тоо, өгсөн арга зүйн дэмжлэгийн тоо | 24 сургууль, 10 зөвлөмж | Эхний хагас жилд: 25 сургууль, 25 зөвлөмж Жилийн эцэст: 25 сургууль, 33 цэцэрлэг, өгсөн зөвлөмжийн тоо 60 | Цахим сургалтын дэд бүтцийг оновчтой зохион байгуулах талаар 2 удаагийн цахим сургалт зохион байгууллаа. Үүнд: Юнител ХХК-ийн орон нутгийн төлөөлөгчийг оролцуулан сургуулийн утасгүй сүлжээний орчин түүний ач холбогдолын талаар сургалт зохион байгууллаа. Сургуулийн захирал нарт Цахим сургалт, түүнийг үр дүнтэй зохион байгуулах арга зүйн сэдвээр мэдээлэл өгч ажилласан. Уг сургалтад 22 сургуулийн захирал хамрагдлаа. 24 сургуулийн мэдээллийн технологийн багш нарт сургуулийн цахим сүлжээний орчин, холболтыг сайжруулах талаар 2 удаа цахим зөвлөмж өгч ажилласан. Боловсролын мэдээллийн технологийн төв, Юнител ХХК-д хандан сургуулийн утасгүй интернэтийг ашиглах арга зүйн сургалтыг төлөвлөөд байна.<br>Хүрсэн түвшин: 24 сургууль, 5 зөвлөмж | 100% |
| 3.2.5 | Багш, суралцагчдын дунд эрх бүхий байгууллагын зөвшөөрсөн олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, | Батлагдсан төсөв, хандив | Олимпиадад оролцсон багш сурагчдын тоо | 25 сургуулийн 1520 багш, сурагч | Эхний хагас жилд: 25 сургуулийн 1520 багш, сурагч Жилийн эцэст: 25 сургуулийн 1600 багш, | Улсын төрөлжсөн олимпиадын II давааг 2024 оны 1 дүгээр сарын 24-өөс 2024 оны 1 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Ховд аймгийн Жаргалант сумын 3-р сургууль, Цаст-Алтай сургууль, Прогресс сургууль дээр 10 судлагдахуунаар Боловсрол, шинжлэх ухааны газар зохион байгуулж нийт 813 сурагч, 362 багш оролцлоо Мэргэжлийн хичээлийн олимпиадыг 2024.12.09-15 ны өдрүүдэд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудад хуваарийн дагуу зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэл, үр дүнг тайлагнах | | | | сурагч | Нийт 11 хичээлээр 1025 сурагч, 415 багш олимпиадад оролцлоо.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 7 файл | |
| 3.3. | Багш, ажилтны хүний нөөцийн хөгжлийг орон нутгийн түвшинд төлөвлөх, зохион байгуулах, нийгмийн баталгааг сайжруулах | Улсын болон батлагдсан төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | Тус зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилтийн дундаж хувь 100 байна. | 100% |
| 3.3.1 | Сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны явц болон үр дүнд хяналт шинжилгээ хийх, зөвлөмж өгөх | Батлагдасан төсөв | Багшийн хөгжлийг дэмжих багш хөгжлийн төвийн тоо | 12 | Эхний хагас жилд: 25<br>Жилийн эцэст: 60 | 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт 1,4 тэрбум төгрөгний тоног төхөөрөмж худалдан авах эрх Ховд аймагт шилжиж ерөнхий боловсролын сургууль тус бүрээс саналыг авч 9 сургууль багш хөгжлийн өрөө тохижуулах хүсэлт гаргасан байна. Уг төсөл арга хэмжээний тендер 5 сард зарлагдаж гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулсан байна.Багш хөгжлийн төвийг сайжруулах зардлыг орон нутгаас 17 сургууль,18 цэцэрлэгт орон нутгийн төсвөөс санхүүжилт шийдвэрлэж өгсөн.<br>Хүрсэн түвшин: 90 | 100% |
| 3.3.2 | Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг | Батлагдсан төсөв | Мэргэжлийн хөгжлийн бүлгийн тоо, хамрагдсан багшийн тоо | 80 | Эхний хагас жилд: 120<br>Жилийн эцэст: 160 | Бага ангийн багш нар мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ багшлахуй болон суралцахуйд тулгамдаж буй асуудлаа илрүүлэн сурагчдын суралцахуйг 6 төрлийн үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх арга зүй, ур чадварын санаагаа хуваалцан ажиллаж байна. Ийнхүү бага | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэх, удирдлага арга зүйгээр хангах | | | | | ангийн 330 багш нараа ажлын байрандаа тасралтгүй хөгжиж багаараа хамтран ажиллаж байна. Мэргэжлийн хөгжлийн бүлгийг эрчимжүүлэх ажлын чиглэл зөвлөмж боловсруулан ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэн ажилласан. Бүх судлагдахууны цахим бүлгүүдийг бий болгож сургалтын хөтөлбөрт тулгамдаж буй асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга замыг судлан хэрэгжүүлж байна. Судлагдахууны багш нарын дунд анги бүлгээрээ нэг бүлэг үүсгэх, элсэлтийн шалгалтын бүлэг, мэргэшлийн ур чадварын бүлэг гэх мэт бүлэг байгуулж ажиллаж нийт 16 судлагдахууны 51 бүлэг ажиллаж байна. Сургуулиудын хувьд багш нарын сонирхлын бүлэг, мэргэшлийн ур чадварын бүлэг зэрэг 3-5 бүлэгт хуваагдан хамтран ажиллаж байна. Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгүүд нь ихэвчлэн Үүнд 1.Хамтран хичээлийн төлөвлөлт боловсруулах, ажлын хуудас, дасгал ажлын дэвтэр боловсруулах 2.Сурагчдын дунд нэрэмжит олимпиад явуулах 3.Элсэлтийн ерөнхий шалгалтыг эрчимжүүлэх сорил авах, сорил шалгалтад зөвлөмж өгөх 4.Судалгаат хичээл зохион байгуулах 5.Багш солилцоо ,чадваржуулах сургалтад хамрагдах 6.Мэргэжлийн гадаад ном зохиолыг хамтран хуваан авч орчуулга хийх зэргээр хамтран ажиллаж байна. Нийт судлагдахууны 51 бүлэгт 900 гаруй багш, суралцахуйд суурилсан бүлгүүдэд бүх багш нар хамрагдан ажлын байранд мэргэжлийн хөгжлөө дэмжин хамтран ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.3.3 | Боловсролын сургалтын байгууллагууд ын зохион байгуулж буй | Батлагдсан төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо, Сургалтад | 54 | Эхний хагас жилд: 45<br>Жилийн эцэст: 45 | 1. Багшийг ажлын байранд хөгжих боломжоор хангах ажлын хүрээнд эхний болон 5, 10 жилийн сургалтад багш нарыг хамруулах судалгааг авч БЕГ-т хүргүүлэн, хамрагдалтын байдалд хяналт тавьж ажилласан. 2. Боловсрол, шинжлэх ухааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт болон орон нутгийн сургалтад багш, ажилтныг хамруулах | | хамрагдсан багшийн тоо | | | яам, Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран зохион байгуулсан “Боловсролын багц хууль” сурталчлан таниулах сургалтыг Ховд аймагт 2024 оны 04 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, Хөгжил политехник коллеж, МУИС-ийн баруун бүсийн сургууль, насан туршийн суралцахуйн төв зэрэг 68 байгууллагын 85 албан хаагч хамрагдсан. 3.Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨААТҮГ-тай хамтран орон нутгийн иргэдээс гарсан санаачилгыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор “Ховд Агро парк” -ийг байгуулан гарааны бизнес эрхлэх иргэдэд зориулсан 10 удаагийн сургалт зохион байгууллаа. 4. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй төслөөр хэрэгжиж байгаа “Онлайн ба хосолсон сургалтын нөөцийг ашиглах арга зүй”-н 3 үе шаттай зохион байгуулагдсан вебинар сургалтад Ховд аймгийн 24 сургуулийн бүх бага ангийн болон 6-12 дугаар ангид Монгол хэл, Математикийн хичээл заадаг нийт 278 багш нарыг хамрууллаа.<br>Хүрсэн түвшин: Боловсролын багц хууль сурталчилан таниулах сургалтыг бүх шатны боловсролын сургалтын 60 байгууллага 100% зохион байгуулсан бөгөөд 3062 багш, ажилчид хамрагдахаас 2561 буюу 83,6%, хамрагдаж мөн 2545 эцэг эх, асран хамгаалагч, 1934 суралцагчдад буюу нийт 7040 хүнд сургалтыг зохион байгуулсан байна. | |
| 3.3.4 | Багш, ажилтан ажлын байрандаа хөгжих, менторыг | Батлагдсан төсөв | Туршлагаа түгээсэн багш ажилтны тоо | 0 | Эхний хагас жилд: 0<br>Жилийн | Сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, шинэ санаа, арга зүйгээ хуваалцах, харилцан туршлага солилцох зорилготой “Багш солилцоо” үйл ажиллагаанд аймгийн төвийн Прогресс, Цаст-Алтай, Жаргалант сумын 7,2 дугаар сургууль, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллуулах, харилцан туршлага солилцох, бүтээлч үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг хөгжүүлэх, тэдний шилдэг арга зүй, технологийг боловсролын технологийн санд бүртгэж, түгээн дэлгэрүүлэх, урамшуулах | | | | эцэст: 0 | Буянт, Чандмань, Алтай, Минжит Булган цогцолбор сургууль нийт 8 сургуулийн 35 багш, удирдлага хамрагдав.Багшлахуйн арга зүй, бүтээлч туршлагуудыг хуваалцан, түгээн дэлгэрүүлэх зорилготой арга зүйд суурилсан судалгаат хичээл I-IV аянд дунд ангийн 10 судлагдахуун бага ангийн 1 нийт 11 хичээлээр Судалгаат хичээл аян зохион хичээлийг зохион байгуулав. Нийт 65 хичээл зохион байгуулагдаж 608 багш ажиглалт хэлэлцүүлэгт оролцов.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 3.3.5 | Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулах, томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, дүнг ил тод, | Батлагдсан төсөв | Сонгон шалгаруулалтаар томилогдсон захирал эрхлэгчийн тоо | 0 | Эхний хагас жилд: 5<br>Жилийн эцэст: 10 | Төрийн албаны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу боловсрол сургалтын байгууллагын удирдах албан тушаалтныг хуульд заасан үндэслэлээр томилох, чөлөөлөх шийдвэрийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Нийт сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 3 /Алтай, Эрдэнэбүрэн, Жаргалант сумын 6-р цэцэрлэг/ эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн /Үенч, Эрдэнэбүрэн, Буянт, Мөнххайрхан, Жаргалант сумын 2 дугаар сургууль, Прогресс/ 6 захирлын ажлын байрны сул орон тооны захиалгыг Ховд аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд судалгаа мэдээллийг хүргүүлж ажилласан. Дээрх 9 ажлын байрны сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг Ховд аймаг дахь Төрийн албаны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нээлттэй мэдээлэх | | | | | салбар зөвлөл зохион байгуулж ажилласан. Ховд аймаг дахь салбар зөвлөлийн тогтоолын дагуу шаардлага хангасан 7 сул орон тоог нөхөж ажилласан байна.<br>Хүрсэн түвшин: 7 | |
| 3.4. | Хүнд суртлаас урьдчилан сэргийлэх | Төсөв шаардахгүй | Зохион байгуулсан ажил арга хэмжээний тоо | 100 | 100 | зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 100% |
| 3.4.1 | Хүнд суртлыг мэдээлэх Товш аппликэйшнд харьяа боловсролын байгууллагууддыг бүртгүүлэх, тус аппликэйшнээр ирсэн иргэдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх | Төсөв шаардахгүй | Аппликэйшнд бүртгүүлэх арга хэмжээ авсан байдал; Иргэдэд аппликэйшн сурталчилсан байдал | Харьяалагдах сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын байгууллагуудыг бүртгүүлэх | Эхний хагас жилд: Бүртгүүлсэн хэмжээгээр Жилийн эцэст: Бүртгүүлсэн хэмжээгээр | Ерөнхий боловсролын 25 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 33 байгууллагын газарзүйн байршлын координат болон холбогдох мэдээ судалгааг гарган Товш аппликэйшны мэйлээр хүргүүлж ажилласан.<br>Хүрсэн түвшин: 58 байгууллага Товш аппликэйшнд бүртгэгдсэн | 100% |
| 3.4.2 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим | Төсөв шаардахгүй | Цахим үйлчилгээнд мониторинг хийсэн байдал | Одоогоор нэвтрүүлсэн байгаа цахим үйлчилгээ | Эхний хагас жилд: Хяналт, үнэлгээ хийсэн, сайжруулах санал гаргасан тоо Жилийн эцэст: Хяналт, | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх тухай мэдээллийг ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт цахимаар сургалт мэдээлэл хийсэн. Боловсролын газрын ахлах арга зүйчид болон боловсролын сургалтын байгууллагын удирдах албан тушаалтнуудын ХАСУМ, болон ХАСХОМ-ыг meduuleg.mn сайтад мэдүүлэн баталгааны хуудсыг цаасаар болон цахимаар авч авлигатай тэмцэх газарт тайлан мэдээг хүргүүлсэн. ХАСУМ, ХАСХОМ-ыг хэрхэн мэдүүлэх талаарх Авлигатай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | | | | үнэлгээ хийсэн, сайжруулах санал гаргасан тоо | тмэмцэх газрын сайтад байршуулсан видео бичлэгийг байгууллагын facebook пэйж хуудсанд байрлуулан нийтэд түгээсэн.<br>Хүрсэн түвшин: Боловсролын газрын дарга, ахлах арга зүйч, 25 сургуулийн захирал, сургалтын менежер, 33 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, салбарын байгууллагын нягтлан бодогч нийт 168 албан тушаалтны ХАСХОМ-ыг хянаж баталгаажуулсан. | |
| 3.4.3 | Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгт холбогдохгүй байх заалт болон хэрэгжүүлэх арга хэмжээг тусган үр дүнг тооцон ажиллах | Төсөв шаардахгүй | Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байгууллагын тоо | Харьяалагдах сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын байгууллагуудын удирдлагатай байгуулсан гэрээний тоо | Эхний хагас жилд: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал Жилийн эцэст: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал | Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгт холбогдохгүй байх болон хэрэгжүүлэх арга хэмжээг тусган үр дүнг тооцон ажиллах тухай зөвлөмжийг салбарын байгууллагуудад хүргүүлж төлөвлөгөөнд тусгуулан ажилласан.<br>Хүрсэн түвшин: Салбарын байгууллагуудын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хэдий ч тайлагналтад оруулсан. 2025 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах талаар захирал, эрхлэгч нарт цахимаар зөвлөгөө өгсөн. | 100% |
| 3.4. | Төрийн | Төсөв | Гэрээнд | Тухайн жилд | Эхний | Боловсролын сургалтын байгууллагын удирдах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | шаардахгүй | авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан гэрээний тоо | байгуулсан гэрээний тоо | хагас жилд: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал Жилийн эцэст: Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал | албан тушаалтнуудад төрийн болон хувийн хэвлийн байгууллагуудтай гэрээ байгуулахдаа авилгаас урьдчилан сэргийлэх, хамаарал бүхий этгээдээс худалдан авалт хийхгүй байх, нийтийн болон хувийн ашиг сонирхолоос ангид байх талаарх зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Мөн дээрх зөвлөмжийн дагуу иргэд, албан хаагчдаас ирүүлсэн гомдлын хүрээнд тухайн цэцэрлэгт хяналт шалгалт хийж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Аливаа гэрээ хэлэлцээрийг захиргааны удирдах байгууллагаар хянуулах шаардлагатайг анхааруулсан. | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 4.1. | Стандарт, техникийн зохицуулалт, хэрэгжилт, эрх зүйн бичиг баримтын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | Энэ зорилтын хүрээнд 5 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан. | 100% |
| 4.1.1 | Боловсролын сургалтын байгууллага, удирдлага, багш болон бусад ажилтан, албан хаагчдын үйл | Батлагдсан төсөв | дотоод хяналт-шинжилгээ нэвтрүүлсэн байгууллагын тоо зөвлөн туслах үйлчилгээ | 60 | Эхний хагас жилд: 62 Жилийн эцэст: 65 | Намрын статистик тайлан мэдээг ерөнхий боловсролын 25 сургууль, насан туршийн 2 боловсрол төвөөс 5 асуулгын нийт 53 маягтаар, төрийн өмчийн 33 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 37 байгууллагаас 3 асуулгын 18 маягтын дагуу захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг гаргуулж өмнөх жилийн мэдээтэй харьцуулж тайлбар авч 12 сургууль, 20 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоо төлөвшүүлэх ажлыг арга зүйн удирдамжаар хангаж зөвлөн туслах, хамтран ажиллах, олон нийтийн оролцоог хангах, зөвлөн туслах, үр дүнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; | | үзүүлсэн байгууллагын тоо | | | цэцэрлэгийн зөрүүтэй тайлан мэдээг арилгахын тулд сургуулийн захирал, сургалтын менжерүүд, нягтлан бодогч, нярав, тогооч, номын санч нартай холбогдож тулгалт хийж зөрчлийг арилгаж ажилласан болно. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт "Дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулах нь" сэдэвт сургалтыг 2024 оны 03 сарын 29-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад 58 байгууллагын 60 эмч, дотоод хяналт шалгалтын багийн ахлагч нар хамрагдлаа. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын ажилтан албан хаагч нарт Дотоод хяналт шалгалтыг хэрхэн тогтмолжуулах талаар байгууллагын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 11 байгууллагын 200 гаруй удирдлага, багш, ажилтан хамрагдсан. Мөн цахим хэлбэрээр 8 байгууллагын Дотоод хяналт шалгалтын багийн 32 ажилтанд мэдээлэл хүргэсэн.<br>Хүрсэн түвшин: Дотоод хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг тогтмолжуулж байна.<br>Хавсралт: 2 файл | |
| 4.1.2 | Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагын үйл | батлагдсан төсөв | зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 25 | Эхний хагас жилд: 30<br>Жилийн эцэст: 45 | 1. БСШУС-ын сайдын 2019 оны А/302 журмын дагуу ерөнхий боловсролын 25 сургуульд түрээсийн сурах бичгийн төлбөр төвлөрүүлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайлан мэдээг Боловсролын яам болон Боловсролын ерөнхий газарт хүргэж захирал, номын санчид зөвлөгөө, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд тогтмол хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх | | | | | чиглэл өгч ажилласан. 2. Жаргалант сумын 1, 2, 3, 5, 8, 13, 14, 16 дугаар цэцэрлэг болон Ховд, Буянт, Эрдэнэбүрэн сумдын сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүллээ.<br>Хүрсэн түвшин: Зөвлөн туслах үйл ажиллагаанд 39 байгууллага хамрагдсан | |
| 4.1.3 | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах | Батлагдсан төсөв | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх гүйцэтгэлийн шалгалтад хамрагдсан байгууллагын тоо | 58 | Эхний хагас жилд: 60<br>Жилийн эцэст: 61 | Боловсролын яамны Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 02 сарын 19-ны өдөр баталсан Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг 11 байгууллага хийлээ. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 5, Ерөнхий боловсролын сургууль 5, Их сургууль 1. Шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15-аас 12 дугаар сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Шалгалтад №03/6.1-1 кодтой Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, №03/6.1-2 кодтой Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, №03/6.1-5 кодтой Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын Дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, №03/6.1-4 кодтой Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах гэсэн 4 төрлийн хяналтын хуудас ашиглалаа. Шалгалтаар бага эрсдэлтэй 2, дунд эрсдэлтэй 4, их эрсдэлтэй 5 байгууллага тус тус үнэлэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шалгалтад хамрагдсан 11 байгууллагад нийт 402 зөрчил илэрсэн ба их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 9 байгууллагад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор 358 заалт бүхий улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага 9 өгч, тухайн байгууллагуудын удирдлага, багш ажилтангуудад байгууллагын сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 4 байгууллагад өгсөн албан шаардлагын хугацаа болж албан шаардлага хариу ирүүлсэн бөгөөд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн. Үлдсэн 5 байгууллагад өгсөн албан шаардлагын хугацаа болоогүй байна<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 4.1.4 | Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн хэмжээнд холбогдох хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийх, их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн | Батлагдсан төсөв | Эрсдлийн үнэлгээ хийсэн сургалтын байгууллагын тоо, эрдслийн үнэлгээ | 65 | Эхний хагас жилд: 0<br>Жилийн эцэст: 65 | Засгийн газраас баталсан Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдлийн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтээр 37 цэцэрлэгт эрсдлийн үнэлгээ хийхэд бага 18, дунд 18, их 1, Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдлийн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтээр 25 Ерөнхий боловсролын сургуульд эрсдлийн үнэлгээ хийхэд бага 0, дунд 25, их 0, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдлийн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтээр 1 политехник коллежид эрсдлийн үнэлгээ хийхэд дунд эрсдэлтэй, Их дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдлийн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтээр 1 их сургуульд эрсдлийн үнэлгээ хийхэд дунд эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн байна. Дээр обьектуудаас их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 10 обьектыг сонгон авч 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн. Үүнд: Жаргалант сумын Ерөнхий боловсролын 6, 7-р сургууль, Манхан, Чандмань, Дуут сумын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шалгалт хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; | | | | | Ерөнхий боловсролын сургууль, Жаргалант сумын 1, 4, 8, 15 дугаар цэцэрлэг, Ховд сумын цэцэрлэг.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 4.1.5 | Орон нутгийн түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, хяналт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулалтаар хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулалтаар хангах | Батлагдсан төсөв | иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоо, гүйцэтгэлийн хяналт шалгалтын тоо | 13 | Эхний хагас жилд: 5<br>Жилийн эцэст: 5 | Тайлангийн хугацаанд Засгийн газрын 1111 төвөөс 1, Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын Үйлчилгээний нэгдсэн төвийн 7043-1111 утсаар -4, Боловсролын газрын 7043-5178 утсаар -2, бичгээр -18 нийт 19 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид хугацаанд нь хүргүүлсэн болно.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2. | Боловсролын сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих, үнэлэх, сайжруулах арга хэмжээг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Улсын болон батлагдсан төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | Энэ зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. | 100% |
| 4.2. 1 | Боловсролын сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, боловсролын чанарыг сайжруулахад өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, политехник коллежийг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах | Батлагдсан төсөв | Сургалтын байгууллагын менежментийн төлөвлөлт боловсруулсан байгууллагын тоо | 60 | Эхний хагас жилд: 60 Жилийн эцэст: 60 | Ховд аймгийн 25 сургуулийн сургуульд суурилсан менежментийг сайжруулах 2023-2024 оны хичээлийн жилийн сургуулийн менежментийг сайжруулах аймгийн нэгдсэн төлөвлөгөө гарган, менежментийг сайжруулах 12 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж байна. Сургуулиудын менежментийг сайжруулах чиглэл 1.Зөвлөгөө 2.Сургалт 3.Зөвлөн туслах 4.Туршлага судлах гэсэн 4 хэлбэрээр зохион явууллаа. БШУГ-ын 8 мэргэжилтэн 8 сургууль хариуцаж, тэдгээр сургуулиуд бусад 17 сургуульдаа түгээн дэлгэрүүлэлт хийж харилцан суралцаж байна. Алтай, Буянт, Мөст, Мөнхайрхан 6, 3, 1 дүгээр сургууль,Цаст-алтай сургуулийн 1655 багш ажилчтан эцэг эх сурагчидтай уулзан 40 хичээлд сууж 6 чиглэлээр хамтран ажиллаж 243 хүнд уулзалт мэдээлэл ярилцлага зохион байгуулав.Нийт 5 удаагийн зөвлөгөө 6 удаагийн сургалт 4 удаагийн туршлага солилцох зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. 2024 оны хичээлийн жилд Жаргалант сумын 16 цэцэрлэг дээр байгууллагын менежмент сайжруулах зорилготой ажиллаж, тус цэцэрлэгийн бүлгийн менежментийг сайжруулан бүх бүлгүүдэд сургалтын төвийн баяжилтийг хийж ажиллав. Эцэг эх олон нийтийн оролцоотойгоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлэг бүр “Ус уух төв”, Хүүхдийн номын төв, Хөл бөмбөгийн талбайг байгууллаа. 2024 оны хичээлийн жилээс туршилтын 2 цэцэрлэг шинээр нэмж байгаа бөгөөд Жаргалант сумын 4, 9 дүгээр цэцэрлэг дээр байгууллагын менежментийг сайжруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Нийт 2 цэцэрлэгийн 23 багш удирдлага, 50 гаруй ажилтанд ажлын байранд дүн шинжилгээ хийж ажиллав.Энэ жилд менежментийн сайжруулах 8:8:3 зарчмын дагуу багуудыг үнэлэн Цаст-Алтай,Дуут,Мянгад сургуулиудыг тус бүр 1 сая төгрөгөөр урамшуулав. Энэ хичээлийн жилд дахин 8 багт хуваан үйл ажиллагаа хэрэгжүүлэнх төлөвлөгөө мөрдөн ажиллаж банйа.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 2 файл | |
| 4.2.2 | Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжүүлж буй гадаад улсын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд хуульд заасан холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Батлагдсан төсөв | Олон улсын хөтөлбөртэй сургалтын байгууллагын тоо хангасан эсэх /тийм-1 үгүй-0/ | 0 | Эхний хагас жилд: 1<br>Жилийн эцэст: 1 | Ховд аймаг дахь Хөгжил Политехникийн коллеж Ази, Номхон далайн бүсийн хүний нөөцийн хөгжлийн техникийн боловсролын ажилтны коллеги (CPSC-Colombo Plan Staff College)-ийн Ази Номхон Далайн Бүсийн Магадлан Итгэмжлэл, Гэрчилгээжүүлэлтийн комисс (APACC)-оор 2028 он хүртэл 4 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдлээ .МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн 4 хөтөлбөр 12 сард магадлан итгэмжлэлд оров.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 4.2.3 | Боловсролын сургалтын | Улсын төсөв | Шилэн кабелийн | 24 | Эхний хагас жилд: | Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дотоод утасгүй сүлжээний тендерийн захиалгад 100 хувь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, утасгүй дотоод сүлжээний болон цахим сургалтын орчныг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх | | сүлжээнд холбогдсон сургалтын байгууллагын тоо, утасгүй сүлжээнд холбогдсон сургалтын танхимын тоо | | 40 Жилийн эцэст: 60 | хамруулж гэрээ байгуулаад байна. Одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл бүрэн хийгдэж хүлээн авсан 4 сургууль, захиалгаа бүрэн хийсэн 20 сургууль байна. Ирэх хичээлийн жилд дотоод утасгүй сүлжээний орчинг бүх сургууль бүрэн бүрдүүлэх нөхцлийг хангаад байна. Цэцэрлэгүүдийн хувьд сүлжээний зураглалыг цахим мэдээллийн системд оруулж өгсөн. Хөдөөгийн шилэн кабель холбогдсон цэцэрлэгүүдэд өөрийн дотоод нөөцөөрөө тоног төхөөрөмжөө шийдэх чиглэл өгч арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: Ерөнхий боловсролын 24 сургууль Юнител компаний access point төхөөрөмжийг барилгын зурагт тохируулсан тоо хэмжээ багцын дагуу худалдан авалт хийж утасгүй интернэтийн орчинг бүрэн бүрдүүлсэн. | |
| 4.2.4 | Газарзүйн мэдээллийн системийн орон зайн дүн шинжилгээнд тулгуурлан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих, | Улсын төсөв | Газарзүйн мэдээллийн системийг ашиглан боловсруулсан сургуулийн байршил, хэв шинжийн төлөвийн саналын тоо | 0 | Эхний хагас жилд: 3 Жилийн эцэст: 5 | Салбарын харъяа 59 байгууллагын барилга байгууламжийн мэдээллийг шинэчилж, БШУЯ болон Аймгийн засаг даргын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Мөн google earth программаар сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны мэдээллийг шинэчилж хүргүүлснээр Газарзүйн мэдээллийн системд оруулсан байна. Ингэснээр барилга байгууламжийн насжилт, хамран сургах тойргийн мэдээлэл, шинэ барилгын төлөвлөлт зэргийг хийхэд илүү хялбар болох юмаа.<br>Хүрсэн түвшин: дээд шатны байгууллагад хугацаанд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөтгөх хэрэгцээ, шаардлагыг элсэлтийн болон хүн амын өсөлтийн байдал, шилжилт, хөдөлгөөний чиг хандлага, нутаг орны хөгжлийн төлөвлөлт зэрэг олон талын хүчин зүйлсийг харгалзан цэцэрлэг, сургуулийн байршил, бүтэц, хэв шинжийг оновчтой тогтоох, өөрчлөн байгуулах, цэцэрлэг, сургуулийн ачааллын тэнцвэрт байдлыг хангах, дахин төлөвлөлт хийх, санал боловсруулж Боловсролын ерөнхий газарт хүргүүлэх | | | | | нь хүргүүлэв | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.5 | Орон нутгийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын сургалтын чиглэл, хөтөлбөрийг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн тодорхойлоход орон нутгийн төрийн байгууллага, ажил олгогч, мэргэжлийн зөвлөлтэй хамтран боловсруулах, түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх, төгсөгчийн хөдөлмөр эрхлэхэд орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран ажиллах; | Улсын төсөв | Орон нутгийн түншлэгчдийн тоо, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь | 15,78 | Эхний хагас жилд: 18,80 Жилийн эцэст: 18,80 | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 33 ангийн 486 суралцагч 388 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн дадлагыг хийж, тайлангаа 100% хамгаалсан. 2023-2024 оны 850 төгсөгчдийн ажил эрхлэлт 71,05%- тай байна.<br>Хүрсэн түвшин: Эхний хагас жилд төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 71.05%, сүүлийн хагас жилд төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 76.5% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.6 | Боловсролын сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлын болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй байдалд мэргэжлийн байгууллага, олон нийт, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тавих хяналтыг тогтмолжуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хүчирхийлэл, гэмт хэрэг, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах үйл ажиллагааг | Улсын төсөв | Хүүхдийн аюулгүй орчин хангасан байгууллагын тоо | 15 | Эхний хагас жилд: 15 Жилийн эцэст: 15 | Сургууль цэцэрлэгийн орчны стандартын үнэлгээ хийж үнэлгээгээр “эрсдэлтэй” гэж үнлэгдсэн камержуулалтын ажлыг аймгийн засаг дарга, цагдаагийн газарт танилцуулж аймаг орон нутгийн бодлого шийдвэрт тусган аймгийн төвийн 16 цэцэрлэг 7 сургуулийн орчинд бүрэн камержуулалт хийлгэж замын уулзвар бүрд гэрлэн гарц байршууллаа. Мөн сургууль орчмын замын тэмдэг 23 ийг нэмэлтээр байршуулж, 3 гарцийг шинээр гаргууллаа. Мөн Жаргалант сумын төвд байрлах сургууль, цэцэрлэгийн ойр орчмын гарц, тэмдэг тэмдэглэгээг нэмэх, сайжруулах арга хэмжээг аймгийн ЗДТГ, Жаргалант ТҮК-аас зохион байгуулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Аймгийн хэмжээнд 46 сургалтын байгууллага хүүхдийн аюулгүй байдлыг хангасан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн бодлого, арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах; | | | | | | |
| 4.2.7 | Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын орчинд хүүхэдтэй зүй бус харилцах хандлага гаргахгүй байх, өсвөр үеийнхнийг дарамт, дээрэлхэлт, хүүхэд, залуучууд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд /цахим орчин, согтуурах, мансуурах, донтох байдалд/ өртөхгүй байх болон хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн судалгаанд суурилсан нөлөөллийн арга хэмжээг холбогдох | Улсын төсөв | Үеийн тэнгийн дээрлэлхэлт, хорт зуршлын бүртгэгдсэн сурагчдын тоо | 0 | Эхний хагас жилд: 0<br>Жилийн эцэст: 0 | Ерөнхий боловсролын сургалтын байгууллагууд давхардсан тоогоор 70 удаагийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, архи, утаат болон электрон тамхины хэрэглээ, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс эрүүл мэндээ хэрхэн хамгаалах, аливаа төрлийн осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх чиглэлүүдээр сургалт, Дэвжээ, АХА тэмцээнүүдийг тодорхой үе шаттайгаар зохион байгуулсан байна. Эдгээр үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд сурагчид тодорхой хэмжээний ойлголттой мэдлэгтэй болсон байна. Сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчдад зориулан давхардсан тоогоор 72 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 11746 эцэг, эх, асран хамгаалагчдыг татан оролцуулсан байна. Эцэг, эх асран хамгаалагчдыг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулснаар сургууль, эцэг ах, сурагчийн хамтын оролцоо нэмэгдэж байна. Хүүхдийг үе тэнгийн дээрэлхэл, дарамт, гадуурхал аливаа төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэднийг зөв хүн болон төлөвшүүлэхэд уриалах, иргэд олон нийтийг татан оролцуулах, нийгмийн соён гэгээрүүлэх, сурталчлан таниулах, хүүхдийн хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгах зорилготой "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аян"-г зохион байгууллаа. Нийт 26 сургуулийн 21000 гаруй суралцагч, 5600 гаруй эцэг эх, асран хамгаалагчдыг шууд болон шууд бус байдлаар /цахимаар, нөлөөллийн ажлаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах | | | | | дамжуулан/ хамруулан аяныг зохион байгууллаа. Сургууль бүр өөрийн онцлогт тохирсон ажлын төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 1 сургууль дунджаар 6-9 үйл ажиллагааг аяны хугацаанд зохион байгуулснаар үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлийн тоо буурах суурь нөхцөл бүрдлээ. Аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газартай хамтран "Бусдын эд зүйл минийх биш" аяныг ерөнхий боловсролын сургуулиудад өрнүүлж идэвхтэй оролцсон 3 байгууллагыг шагнаж урамшуулсан.<br>Хүрсэн түвшин: 2 аян, сургалт сурталчилгааны ажил зохион байгууллаа. | |
| 4.2.8 | Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын уялдаа холбоог хангах, сайн туршлага, бүтээлч ажлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах | Улсын төсөв, үйл ажиллагааны зардал | Түгээн дэлгэрүүлсэн арга зүй, тэргүүн туршлагын тоо | 16 | Эхний хагас жилд: 32<br>Жилийн эцэст: 50 | Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр үндэсний хэмжээнд Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэг, Зэрэг сумын цэцэрлэгийн “Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллаж байгаа ажлын арга туршлага”, Жаргалант 12 дугаар цэцэрлэгийн багш М.Цэцэгсүрэнгийн “Хүүхдийн хувийн хавтас бүрдүүлж ажиллаж байгаа арга туршлага” баруун бүсийн 5 аймагт, Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн багш нарын хүүхэд хөгжүүлж буй арга туршлагыг түгээн дэлгэрүүлж ажиллав. Ажлын арга туршлагыг цэцэрлэгийн 262 багшид түгээн дэлгэрүүлж ажиллав. “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” (СБААХ) -ын арга, аргачлалаар сургуулийнхаа өөрийн үнэлгээг хийж сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх үйл явцыг хэрэгжүүлж, байгууллагын хөгжлийн түвшин тодорхойлох арга аргачлалыг танилцуулж, цаашдын үйл ажиллагаа төлөвлөлтдөө тусгах боломжуудыг 1, 2, Мөнххайрхан, Буянт зэрэг загвар 4 сургууль түгээн дэлгэрүүллээ. Тус арга хэмжээнд зориулан ТХБ-дэд хөтөлбөрөөс 5700000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Нийт 25 сургуулийн 130 багш удирдлага ажилчид оролцлоо. Арга хэмжээний үеэр нээлттэй хичээл - 12, тэргүүн туршлага -25, хэрэгжсэн төсөл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийн танилцуулга -4, үзэсгэлэн -4 гэх мэт үйл ажиллагааг зохион байгууллаа. Боловсролын яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсэн "Сургуульд суурилсан менежмент" төсөлд хамрагдсан 8 сургууль Боловсролын газраас гаргасан төлөвлөгөөний дагуу бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан. 2024 оны 11 дүгээр сард төслийн тайлант хэлэлцүүлэгт 8 сургуулийн удирдлага оролцож тайлангаа хэлэлцүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Цэцэрлэгийн 3, ерөнхий сургуулийн 25 туршлагыг түгээн дэлгэрүүлж ажилласан. | |
| 4.3. | Салбарын орон нутаг дахь байгууллагын худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын явцад хяналт хийх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, санал боловсруулах | Улсын болон батлагдсан төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 7 төсөл арга хэмжээнд 10,5 тэрбум төгрөг, үргэлжилж байгаа 6 төсөл арга хэмжээнд 12,6 тэрбум төгрөг, Аймгийн ОНХС хөрөнгө оруулалтаар 8,4 тэрбум төгрөгний батлагдсан төсөвтэй, худалдан авах ажиллагааг гэрээний хугацааны хамт явцын хяналтыг хэрэгжүүлж байна. Сумын ОНХС хөрөнгө оруулалтаар 14 сумдад 2,2 тэрбум төгрөг батлагдаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жил дуусч байгаа тул зуны амралтын хугацаанд их засвар, худалдан авалт, нийлүүлэлт хийгдэхээр хүлээгдэж байна. | 100% |
| 4.3.1 | Салбарын хөрөнгө оруулалтын судалгаа, мэдээ, тайлан гаргах | Улсын төсөв, орон нутгийн төсөв | улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээ, судалгааг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | тийм | Эхний хагас жилд: тийм Жилийн эцэст: тийм | 2024 онд хүлээн авах төсөл арга хэмжээ буюу 1 сургууль, 2 цэцэрлэг, 2 дотуур байрны явцын хяналтын мэдээлэл, 2024-2026 онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт 7 төсөл арга хэмжээний судалгаа, мэдээлэл, 2025-2027 онд хэрэгжих улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, саналыг хуулийн хугацаанд хүргүүлж байна. Мөн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тоног төхөөрөмж, их засварын ажлын явц, гүйцэтгэл хянан ажиллаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотуур байрны тоног төхөөрөмж, сургалтын байгууллагын тоног төхөөрөмжийн судалгааг Боловсролын мэдээллийн системээр нэгтгэн хүргүүллээ. 2025 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засвар, тоног төхөөрөмжийн арга хэмжээ мөн 2025-2028 он буюу аймгийн засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн Аймгийн ИТХ-д хүргүүллээ.<br>Хүрсэн түвшин: Хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэв | |
| 4.3.2 | Санхүүжилтийг зохион байгуулах, хянах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв, орон нутгийн төсөв | Төсвийн гүйцэтгэлийг 100% хүргэх, төсвийг зөв зохистой удирдах | 0 | Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100% | -2025 оны төсвийн төсөл, багш, ажилтаны хөдөө орон нутгийн тэтгэмж, тэтгэвэрт гархад олгох нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой засгийн газрын журам зааврыг танилцуулан мэдээлэл өгөх уулзалтыг цахим уулзалтын линкээр ЕБС-24, СӨБ-33 цэцэрлэгийн багш, ажилтанд 05 сарын-27-30 хооронд удирдамж гарган хүргэж ажиллав. Мөн мэдээлэл өгөх уулзалтыг Жаргалант сумын 7 сургууль, 16 цэцэрлэгийн 21 нягтлан бодогч танхимаар, Бусад сумдын сургууль, цэцэрлэгийн 19 нягтлан бодогч цахимаар хамруулан нэгдсэн ойлголт өгч багш, ажилтаныг орхигдуулахгүй ажилласан жил, үдсэн болон дундаж цалинг зөв тооцох талаар мэдээлэл сургалт өгөв. -Боловсролын салбарын төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл, хууль эрх зүй, аудит, хөрөнгө оруулалтад анхаарах асуудал, сургууль, цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээ баталсан Засгийн газрын тогтоол болон Боловсролын сайдын тушаалаар баталсан заавар журам, Санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын зөвлөмж, түүний биелэлт, Санхүүгийн ажилтаны сайн туршлага, арга зүйтэй танилцах, төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргахад анхаарах асуудлын талаар албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024-11 сарын 15-16 нд Боловсролын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн газар, Аудитын газар, Татварын газар, Нийгмийн даатгалын газрууд тус тус төсөв санхүүтай холбоотой мэдээллийг өгөв. Сургалтад Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсрол, Насан туршийн боловсролын төв хариуцсан 39 нягтлан бодогч танхимаар хамрагдав. -Боловсролын салбарын Нягтлан бодогч нарыг байнгын шуурхай удирдлага, арга зүйгээр ханган ажиллах үүргийн дагуу /Шинээр гарсан хууль, тогтоомж, тушаал шийдвэрийг / Цахим болон гар утсаар дамжуулах мэдээллийг хүргэж лавлагаа мэдээлэл тогтмол өгч ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн Багш, ажилтанд цалин, амралт, нийгмийн баталгаатай холбоотой хууль, тогтоомжийн хүрээнд мэдээлэл зөвлөгөөг утсаар болон биечлэн хүргэж ажиллав.<br>Хүрсэн түвшин: Төсвийн зардал бүр зөв, оновчтой, зориулалтын дагуу зарцуулагдсан.<br>Хавсралт: 15 файл | |
| 4.3.3 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах | орон нутгийн төсөв | Батлагдсан хөрөнгө оруулалтыг хугацаанд нь хүлээн авах, ажлын даалгаварыг чанаржуулах, гүйцэтгэлийг хянах | 2,7 тэрбум | Эхний хагас жилд: 2,5 тэрбум Жилийн эцэст: 7,1 тэрбум | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 8,4 тэрбум төгрөгийг баталж үүнд 15 байгууллагын их засварт 2,3 тэрбум төгрөг, хөдөөгийн сумдын дотуур байрны хатуу эдлэлийн шинэчлэл , ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ширээ, сандал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын СТЕМ тоглоом, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж зэрэг хүүхдэд ээлтэй хүний хөгжлийг дэмжсэн жилийн хүрээнд 1,5 тэрбум төгрөгний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хүлээн авч тэгш хүртээмжтэй хуваариллаа. Мөн Орон нутгийн дэмжлэгээр Сүү хөтөлбөрт 1,7 тэрбум төгрөгийг баталж Ховд аймгийн 16,159 хүүхэд 7 хоногт 2 удаа сүү ууж хүүхэд бүрт сүү хөтөлбөр амжилттай хэрэгжиж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 4.4. | Салбарын орон нутаг дахь байгууллагын төсвийн гүйцэтгэл, хэрэгжилт зохицуулалт | Улсын төсөв | Арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээ бүрийн суурь түвшин | Арга хэмжээ бүрийн зорилтот түвшин | 2024 оны 6 сарын байдлаар 6 сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байр орчин үеийн ариун цэврийн байгууламжид холбогдох ажил хийгдэж байна. Үүнд Дарви, Чандмань, Буянт сумдыг Ховд Шинэ Асар ХХК, Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сумдыг Алтайн газрын хүч ХХК хийж гүйцэтгэж байна. Мөн 2024 онд шинээр хийгдэх 3 сумдын зургийн компани шалгарч, тендер зарлагдсан байна. | 100% |
| 4.4.1 | Хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг нэгтгэж дээд шатны байгууллагад хүргүүлэх | улсын төсөв | 59 байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэж хүргүүлэх | 0 | Эхний хагас жилд: 59 байгууллага<br>Жилийн эцэст: 59 байгууллага | Төсвийн тухай хуулийн дагуу хагас жилийн санхүүгийн тайланг 2024 оны 7 сарын 25-ны дотор нэгтгэн харъяалах дээд шатны байгууллагад хүргүүллээ. Харъяа 59 байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланд нийт 58,2 тэрбум төгрөгний батлагдсан төсөвтэй 50,8 тэрбум төгрөг буюу 87,2% төсвийн гүйцэтгэлтэй мөнгөн гүйлгээний тайлан нэгтгэгдлээ. 2024 оны жилийн эцэс болж байгаа тул төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж санхүүгийн тайлан хугацаанд нь нэгтгүүлэх, алдаа зөрчилгүй ажиллах талаар зөвлөн тусалж байна. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 2024 оны 5 сард баталгаажиж нийт 59 байгууллагаас 55 байгууллага зөрчилгүй, 4 байгууллага зөрчилтэй дүгнэгдэж 93,2% гүйцэтгэлтэй байна.<br>Хүрсэн түвшин: Харъяа 59 байгууллагын тайланг хуулийн хугацаанд нэгтгэж хүргүүлэв. | 100% |
| 4.4.2 | Салбарын харъяа байгууллагын сарын мэдээ, өр авлагыг нэгтгэж төсвийн | улсын төсөв | Авлага, өр төлбөргүй ажиллах, төсвийн нээлттэй ил тод байдлыг хангуулах | 0 | Эхний хагас жилд: 20 байгууллага<br>Жилийн эцэст: 59 | Сургууль, Цэцэрлэгийн 1-9 сар, 10, 11, 12 сарын үүссэн өглөг ЕБС -306,3 сая.төг эх үүсвэрийг шийдвэрлэв. нэмэлт орлого буюу өөрийн орлого болон бусад эх үүсвэрээр бий болсон орлого зарцуулах эрхийг холбогдох баримтад үндэслэн сар бүр эрх нээж төсвийн хуваарьт өөрчлөлт оруулав . Мөн хоол тэжээлийн дэмжлэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуваарьт өөрчлөлт оруулах санал өгөх, шилэн дансны хэрэгжилтийг хангуулах | | | | байгууллага | хөтөлбөрийн санхүүжилтыг ЕБС 1-5 анги, СӨБ хүүхдийн тоог шинэчлэн авч 5-12 сарын орлого төлөвлөлт хийж хүргүүлэн 961,6 сая.төг санхүүжилт хувиарлан, зарцуулах эрх нээлгэж ажиллав. Түүвэр байдлаар 24 сургууль, 37 цэцэрлэгийн шилэн дансны мэдээлэлд хяналт хийж ажиллав. Мөн хуулийн хугацаандаа мэдээллээ үнэн зөв оруулах талаар мэдээлэл зөвлөгөөг нэгж байгууллагын санхүүгийн ажилтануудад сар бүр мэдээлэл өгч ажилласан.<br>Хүрсэн түвшин: Өр төлбөр, авлагагүй ажилласнаар сургалтын хэвийн үйл ажиллагаа хангагдаж, төсөв ил тод мэдээлэх боломж бүрдэв.<br>Хавсралт: 3 файл | |
| 4.5. | Орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох, сургалтын эрүүл, аюулгүй орчныг бий болгох | Улсын төсөв | Стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийн тоо, эрүүл аюулгүй орчныг бий болгох | 16 сургууль,26 цэцэрлэг, 12 дотуур байр | 24 сургууль, 33 цэцэрлэг, 18 дотуур байр | Хагас жилийн байдлаар оны эцсийн үлдэгдлийн зарцуулах эрх нээгдсэн, шинээр үүссэн өр төлбөргүй ажиллаж байна. Эхний 5 сарын байдлаар 41 тэрбум төгрөгний батлагдсан төсөвтэй, 35,5 тэрбум төгрөгний гүйцэтгэлтэй төсвийн зарцуулалт 97%-тай байна. | 100% |
| 4.5. 1 | 2023-2024 онд ашиглалтад орох ариун цэврийн байгууламжийн явцад хяналт хийх, бүрэн ашиглалтыг нэмэгдүүлэх | улсын төсөв | 2023 онд 6 сум, 2024 онд 3 сум | 0 | Эхний хагас жилд: 6 сум Жилийн эцэст: 3 сум | 2023 онд 6 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байр ашиглалтад орохоор төлөвлөж 2024 оны 6 сард 5 сум буюу Буянт, Чандмань, Дарви, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын сургууль, цэцэрлэгг, дотуур байрыг улсын комисс хүлээн авч 2024-2025 оны хичээлээс жилээс хэвийн ашиглаж эхэллээ. Ховд сумын сургууль, цэцэрлэг, дотуур байранд угсралтын ажил хийгдэж дууссан ч ажлын гүйцэтгэл 90% байна. 2024-2025 онд хийгдэх 3 сумдын буюу Манхан, Дөргөн, Булган 1-р цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 70-90% гүйцэтгэлтэй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна.<br>Хүрсэн түвшин: 2023-2024 онд 6 сум, 2024-2025 онд 3 сум нийт 9 сум<br>Хавсралт: 1 файл | |

Тайланг хянасан: **Төсвийн ерөнхийлөн захирагч**

БОЛОВСРОЛЫН САЙД ................................ /П.НАРАНБАЯР/

(албан тушаал ) (гарын үсэг) Тэмдэг ..................... (огноо)

Тайлагнасан: **Төсвийн шууд захирагч**

ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА ................................ /В.САЙНБАЯР/

(албан тушаал ) (гарын үсэг) Тэмдэг 2024.12.19 (огноо)